

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЦЭНГЭЛ СУМЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (2014-2024 ОН)

Боловсруулсан ажлын хэсэг:

Б.Аль-Хасен,	Засаг даргын орлогч, БУ-ын магистр
Б.Ерболат,	Засаг даргын тамгын газрын дарга
Т.Насанбат,	Тыва бага сургуулийн захирал
Х.Жексенбай,	Руханият бүрэн дунд сургуулийн захирал
А.Алтынбек,	Тэтгэвэр, тэтгэмж хариуцсан улсын байцаагч
С.Тилеубай,	Байгаль орчны хяналтын улсын байцаагч
Э.Лаура,	Иргэний танхимын зохицуулагч

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЦЭНГЭЛ СУМЫН
ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
(2014-2024 ОН)**

Редактор: Я.Шуурав Монгол улсын гавьяат багш, профессор
Эхийг бэлтгэсэн: М.Нарангэрэл

Уран Өнгө ХХК-д хэвлэв.

2014 он

ГАРЧИГ

ӨРГӨЛ ҮГ ТАЛАРХАЛ

Нэгдүгээр бүлэг. СУМЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХУРААНГУЙ

1.1. Хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад баримталсан зарчим, арга зүй

1.1.1. Хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад баримталсан зарчим, үйл
явц, арга зүй

1.1.2. Төлөвлөгөө боловсруулах үндэслэл, шаардлага

1.2. Зохион байгуулалт ба зохицуулалтын арга хэмжээ

1.2.1. Ажлын хэсэг

1.2.2. Төлөвлөлт, хяналтын хороо

1.2.3. Төлөвлөгөөний төслийн хэлэлцүүлэг

Хоёрдугаар бүлэг. СУМЫН ХӨГЖЛИЙН ОРЧНЫ ОДООГИЙН БАЙДАЛ

2.1. Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын танилцуулга

2.1.1. Сум байгуулагдсан түүх

2.1.2. Газар зүйн байршил, ан амьтан, газрын гадарга, цаг уур

2.1.3. Байгалийн баялаг, түүх дурсгалын болон үзэсгэлэнт газрууд

2.2. Нутгийн удирдлагын зохион байгуулалт

2.2.1. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага

2.2.2. Нутгийн захиргаа

2.3. Сумын чадавхийн үнэлгээ

2.4. Эдийн засгийн үндсэн салбарууд

2.4.1. Мал аж ахуй

2.4.2. Газар тариалан

2.4.3. Жижиг, дунд үйлдвэрлэл

2.4.4. Аялал жуулчлал, үйлчилгээний бусад салбарын хөгжил

2.4.5. Дэд бүтэц

2.4.6. Хүний нөөц, амьжиргааны чадавхи

2.4.7. Орон нутгийн төсөв

2.5. Албан байгууллагын товч танилцуулга

- 2.5.1. Боловсролын салбар
- 2.5.2. Сургуулийн өмнөх боловсрол
- 2.5.3. Соёлын үйлчилгээ
- 2.5.4. Эрүүл мэндийн үйлчилгээ

2.6. Иргэд, оролцогч талуудын оролцооны үнэлгээний дүн

- 2.6.1. Бизнес орчны судалгааны дүгнэлтүүд
- 2.6.2. SWOT шинжилгээний матриц, дүгнэлтүүд
- 2.6.3. Сумын тулгамдсан гол асуудлууд
- 2.6.4. Эдийн засгийн гол зорилтууд

Гуравдугаар бүлэг. СУМЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

- 3.1. Хөгжлийн алсын хараа, сумын хөгжлийн тэргүүлэх чиглэл
- 3.2. Сумын хөгжлийн төлөвлөгөөний үндсэн чиглэлийг хангах зорилго, зорилтууд
- 3.3. Төлөвлөгөөг хэрэгжүүлэгч талууд, тэдний оролцоо, хүлээх үүрэг
- 3.4. Хөрш зэргэлдээ сумуудтай хамтран ажиллах
- 3.5. Сумын хөгжлийн зорилго, зорилтуудын хүрээнд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийн тойм

Дөрөвдүгээр бүлэг. ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭРЭГСЭЛ

- 4.1. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын удирдлага, зохион байгуулалт
- 4.2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө санхүүгийн асуудлын зохицуулалт

Тавдугаар бүлэг. ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ

- 5.1. Хяналтын хэлбэр ба зохион байгуулалт
- 5.2. Хяналтын үнэлгээний үе шат, тайлагнах тогтолцоо

Зургаадугаар бүлэг. ХАВСРАЛТУУД

- 6.1. Үйл ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөө
- 6.2. 2014-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хийх мониторингийн төлөвлөгөө
- 6.3. Мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагааны төлөвлөгөө

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ	-	Аж ахуйн нэгж, байгууллага
АХ	-	Ажлын хэсэг
БОС	-	Бизнес орчны судалгаа
БНХАУ	-	Бүгд найрамдах Хятад ард улс
БШУЯ	-	Боловсрол Шинжлэх ухааны яам
Га	-	Гектар
ГТХАН	-	Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг
ЖДҮ	-	Жижиг, дунд үйлдвэр
ЗДТГ	-	Засаг даргын Тамгын газар
ЗГ	-	Засгийн газар
ЕБС	-	Ерөнхий боловсролын сургууль
ИТХ	-	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИНХ	-	Иргэдийн нийтийн хурал
МАА	-	Мал аж ахуй
МАНТХГ	-	Монгол Алтай нурууны тусгай хамгаалалттай газар
МХГ	-	Мэргэжлийн хяналтын газар
ОНЭЗХ	-	Орон нутгийн эдийн засгийн хөгжил
ОУБ	-	Олон улсын байгууллага
ОУ	-	Олон улс
ОХУ	-	Оросын Холбооны Улс
ОНХС	-	Орон нутгийн хөгжлийн сан
СДЭ	-	Сум дундын эмнэлэг
СХТ	-	Сумын хөгжлийн төлөвлөгөө
СӨБ	-	Сургуулийн өмнөх боловсрол
ТББ	-	Төрийн бус байгууллага
ТХХ	-	Төлөвлөлт хяналтын хороо
ХАА	-	Хөдөө аж ахуй
ХБИ	-	Хөгжлийн бэршээлтэй иргэн
ХГБХТ	-	Хүүхэд, гэр бүл хөгжлийн төв
ХХК	-	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦШСГ	-	Цахилгаан шугам сүлжээний газар
ЭМЯ	-	Эрүүл мэндийн яам
FM	-	Богино долгионы радио нэвтрүүлэг
SWOT	-	Давуу болон сул тал, боломж, бэрхшээлийн судалгаа



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ
ЦЭНГЭЛ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 08

Хөшөөт Төв

Сумын хөгжлийн төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “а”, 18.1.2-ын “е” дэх заалтуудыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Орон нутгийг хөгжүүлэх “Сумын хөгжлийн төлөвлөгөө”-г /2014-2024/ хавсралтаар баталсугай.

Хоёр. Хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан төслүүдийг жил бүрийн сумын нийгэм эдийн засгийн зорилтод тусган хэрэгжилт, үр дүнг тооцож ИТХ-ын хуралдаанд тайлагнаж ажиллахыг ИТХ-ын Тэргүүлэгчид болон сумын Засаг даргад үүрэг болгосугай.



ДАРГА

Б.БАДАМЦЭЦЭГ

ӨРГӨЛ ҮГ



Алтай Таван богдын бэлээс, ард түмэнийхээ өмнөөс уншигч тантай мэндчилж байна. Төрсөн нутгийнхаа хөгжил дэвшлийн төлөө боловсруулсан хөгжлийн төлөвлөгөөгөө дэлгэж барья. Бид сумын хөгжлийн хэтийн төлөвлөгөөгөө иргэдийнхээ оролцоотойгоор, өөрийн нутгийн онцлогт тохируулан боловсруулж та бүхэндээ хүргэж байна. Сумын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, сумын иргэд, малчид, бизнес эрхэлэгчид, сургуулийн сурагчид, нутгийн зөвлөл, тус сумаас төрөн гарсан эрдэмтэд зэрэг хүмүүсийн санал өргөн тусгагдсан нь хөгжлийн чиг хандлагыг оновчтой тодорхойлоход ашиг тустай болсныг талархан тэмдэглэж байна.

Энэ төлөвлөгөө хэрэгжсэний үр дүнд Сумын иргэдийн ажиллаж, амьдрах таатай, эрүүл орчин бүрдэнэ. Мөн төрийн болон төрийн бус байгууллагыг бэхжүүлэх, жижиг дунд үйлдвэрүүдийг хөгжүүлэх, байгаль орчноо хамгаалахад ахиц гарч, ажлын байр нэмэгдэн эдийн засгийн тогтвортой өсөлт бий болж, сумын нийгэм эдийн засгийн хэтийн хөгжилд мэдэгдэхүйц дэвшил гарна гэдэгт итгэж байна.

Та бүхний оюуны мэлмий тунгалаг байх болтугай.

Цэнгэл сумын ИТХ-ын дарга Б.Бадамцэцэг

ТАЛАРХАЛ



Манай сум хөгжлийн гэрэлт төв болсон нийслэл Улаанбаатар хотоос хамгийн хол зайд, Монгол улсын хамгийн баруун хязгаарт, нийгэм эдийн засаг, хөгжил, зах зээлээс алсад оршдог боловч нутгийн хөдөлмөрч ард түмэн, эрдэмтэн мэргэд маань сумынхаа хөгжлийн төлөө эрдэм мэдлэг, оюун ухаан, ариун цагаан хөдөлмөрөө харамгүй зарцуулж 90 жилийн хугацаанд сумынхаа хөгжлийг улсын тэргүүний сумуудын хэмжээнд хүргэж чадлаа.

Сумынхаа хөгжлийн хэтийн төлөвлөгөөг бид 2006 онд боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн ба түүнд тусгасан зорилтууд биелж

хэрэгжсэн. Сумынхаа хөгжлийг улс орны хөгжлийн шинэ зорилтуудтай нийцүүлэн тодорхойлох зорилгоор 2014-2024 оны Сумын хэтийн төлөвлөгөөгөө шинэчлэн боловсруулан гаргаж байгаад талархалтай байна. Сум орны онцлог, казак, тыва ард түмний зан заншил, түүх, соёл, газар нутгийн байгалийн нөөц, баялаг, иргэдийн хөдөлмөрч чанар, оюуны потенциалын хөгжил, өнөө цагийн чадавхи, ирээдүйн боломжийг тооцоолон судалж хөгжлийн гарцаа тодорхойлж байгаа нь энэхүү хөтөлбөрийн гол үндэс юм. Бидний боловсруулсан дунд хугацааны хэтийн төлөвлөгөөг сумын иргэд, байгууллага хамт олон чин сэтгэлээсээ хүлээн авч, санал бодлоо хэлж, дэмжин туслаж байгаад талархаж байна. Цэнгэл сум нь онгон дагшин газар нутагтай, ашигт малтмалын болон байгалийн нөөц баялагтай. Гадаад дотоодынхоны сонирхол татсан үзэсгэлэнт газар нутгаа түшиглэн аялал жуулчлал, өндөр уулын бүсэд тохирсон МАА-г хөгжүүлэх боломжтой. Хүний хөгжлийг дээдэлэн казах, тыва ард түмний онцлогт тохируулан хөгжих чадамжтай. Унаган нутгийнхан байгальдаа ээлтэй сум болох хөгжлийн зорилго дэвшүүлж, Цэнгэлээ гэсэн нутгийн иргэд, гадаад, дотоодын хүмүүс ирж, бидний хөгжлийн төлөвлөгөөтэй танилцаж, хамтран ажиллахад бэлэн байгаагаа илэрхийлж байна. Манай сумын иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд төрөлх нутгаа гэсэн хөгжлийн

төлөвлөгөөг ажил хэрэг болгоход сэтгэл санаа нэгтэйгээр хошуучлан оролцож, хөдөлмөрлөнө гэдэгт итгэж, бас та бүхнийгээ уриалж байна.

Энэхүү хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан гаргахад арга зүйн болон санхүүгийн дэмжлэг үзүүлж хамтран ажилласан Нутгийн удирдлагын холбоо, Мерси-Кор олон улсын байгууллага, хөтөлбөрийг гардан боловсруулсан сумын ажлын хэсэг, оюун санааны хувь нэмэр оруулсан бүх хүмүүст чин сэтгэлээсээ талархал илэрхийлье.

Цэнгэл сумын Засаг дарга Т.Ташкен

Нэгдүгээр бүлэг. СУМЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХУРААНГУЙ

Сумын хөгжлийн төлөвлөгөө боловсруулах арга зүйн гол үндэс нь сумын иргэд, олон нийтийн оролцоон дээр тулгуурлан тэдний санал бодол, хүсэл, зорилгыг сонсож, хамтран ажиллах явдал байв. Нөгөө талаас хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжихүйц, бодитой болгоход оролцооны аргыг ашиглаж, аль болох олон иргэдийг хамруулах нөхцөл боломжийг бүрдүүлэх явдал чухал болох нь судалгааны явц, үр дүнгээс харагдлаа.

Санал асуулгын анкетаар 450 иргэн, БОС-ны анкет, SWOT анализ, асуудлын ба шийдлийн модны арга, чадавхийн судалгааны ажилд нийтдээ 306 иргэн, ганцаарчилсан ярилцлагад 24 иргэн, олон нийтийн хэлэлцүүлэгт /багийн ИНХ/ 300 гаруй иргэн оролцов.

Цэнгэл сумын иргэдээс авсан судалгааны материалыг үндэслэн сумын хөгжлийн төлөвлөгөөний төслийг боловсруулсан болно. Ингэхдээ алсын хараатай, 3 тэргүүлэх чиглэл, таван зорилго, 19 зорилт, 28 хөтөлбөр, 114 төсөлтэй сумын хөгжлийн урт хугацааны төлөвлөгөө гарсан болно.

Хөгжлийн төлөвлөгөөг оролцооны аргаар боловсруулснаар дараах ач холбогдолтой хэмээн дүгнэж байна. Үүнд:

1. Улс төрийн сонгуулийн үр дүнгээс үл хамааран сумын удирдлага тухайн хөгжлийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа тогтвортой, урт хугацаанд явуулах боломж бүрдэнэ.
2. Тухайн бүс нутагт улс төрийн намууд хэт туйлшралгүй хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан мөрийн хөтөлбөрөө дэвшүүлж, иргэд сонгогчдоор үнэлүүлж, дүгнүүлэх нөхцөл бүрдэнэ.
3. Нөөц боломжид тулгуурласан учраас төлөвлөгөөнд тусгагдсан аливаа төсөл, хөтөлбөр үндэслэлтэй, хэрэгжих боломжтой болно.
4. Дээд шатны төрийн байгууллага, сумын удирдлага болон ард иргэдийн санал бодол, хүсэл эрмэлзлэл, тэмүүлэл бүрэн тусгагдсан учраас төлөвлөгөөний биелэлтийн төлөө хариуцлага нэгдмэл бөгөөд өндөр байх үндэстэй.
5. Иргэдийн оролцоо хангагдсан, тооцоо судалгаа нарийвчлан хийгдсэн учраас төлөвлөгөө “ухаалаг (SMART – өвөрмөц, хэмжигддэг, хэрэгждэг, бодитой, цаг хугацаатай)” болох бололцоотой болно.
6. Дэлхий нийтээрээ, ялангуяа Монгол улсад шууд ардчиллын зарчмуудыг оролцооны аргаар хэрэгжүүлэх чиг замыг сонгож байгаа учраас орон нутагт шууд ардчиллыг хэрэгжүүлэхэд төлөвлөлтийн энэ арга зүй ашиг тусаа өгнө.

Ажлын хэсэг

1.1. Хөгжлийн цогцолбор төлөвлөгөө боловсруулахад баримталсан зарчим, арга зүй

1.1.1. Хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад баримталсан зарчим, үйл явц, арга зүй

Төлөвлөгөөг боловсруулахдаа Мерси Кор Монгол ОУБ-аас Монголд анх удаа хэрэглэсэн арга зүй, туршлага, санал, дүгнэлтэнд тулгуурласан орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөг оролцооны аргаар төлөвлөх зөвлөмж бичгийг үндэс болгов. Энэ зөвлөмж бичгийг үндэс болгож судалгааны ажлыг явуулсан.

Сумын хөгжлийн төлөвлөгөө боловсруулах арга зүйн гол үндэс нь сумын иргэд, олон нийтийн оролцоон дээр тулгуурлан тэдний санал бодол, хүсэл, зорилгыг сонсож, хамтран ажиллах явдал байв. Нөгөө талаас хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжихүйц, бодитой болгоход оролцооны аргыг ашиглаж, аль болох олон оролцогчийг хамруулах нөхцөл боломжийг бүрдүүлэх явдал чухал байв.

Иргэдийн оролцоог ашиглан хөгжлийн төлөвлөгөө боловсруулах явцад сумын өнөөгийн төлөв байдалд шинжилгээ хийж, үндэслэл, дүгнэлт гаргаж анализ боловсруулалт хийсэн. Цэнгэл сумын өнөөгийн төлөв байдал, цаашдын чиг хандлагын талаар асуусан асуулга боловсруулж 450 иргэнээс /тухайн нутаг дэвсгэр, засаг захиргааны хувьд 3 өрхөөс 1 хүн аливаа төсөл, хөтөлбөрийн санал асуулгад оролцсон тохиолдолд хүчинтэй байна гэж үздэг/, чадавхийн судалгааг 100 иргэнээс санамсаргүй түүврийн аргаар, БОС-г боловсруулсан асуулгын дагуу 90-ээд бизнес эрхлэгчдээс судалгаа авч дүгнэв.

Сум, орон нутгийн төлөвлөгөөнд ирээдүйг хэрхэн төсөөлж байгаа талаар зорилтот бүлгийг оролцуулсан фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлага, хэлэлцүүлэг явуулсан. Мөн албан байгууллага, аж ахуйн нэгж, бизнес, иргэдийн төлөөллөөс SWOT шинжилгээ, асуудлын ба шийдлийн модны аргаар 300 гаруй иргэнээс судалгаа авч дүгнэлээ.

1.1.2. Төлөвлөгөө боловсруулах үндэслэл, шаардлага

Орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх нь шилжилтийн болон хөгжиж буй орнуудын засгийн газрын хувьд тулгамдсан зорилт болж байна. Монгол улсын хувьд ядуурал, ажилгүйдэл буурахгүй байгаа, хот, хөдөөгийн хөгжлийн түвшний ялгаа улам ихэсч, үндэсний орлогын тэгш бус хуваарилалтаас үүдэлтэй нийгмийн

тэнцвэргүй байдал гүнзгийрэх чиг хандлагатай болж, хүний хөгжил удааширч байгаа нь богино хугацаанд эдийн засгаа эрчимтэй хөгжүүлэх тэр тусмаа орон нутгийн жигд хөгжлийг хангах хэрэгцээ шаардлагыг бий болгож байна. Нөгөө талаас Монгол Улсын Их Хурал 2001 онд “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, 2008 онд “Мянганы хөгжлийн зорилтот суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”-ыг баталсан ба 2021 он хүртэл бүс нутгийн хүрээнд аймаг, орон нутгийг эдийн засгийн талаар бие даан хөгжүүлж, нутаг дэвсгэрийн харьцангуй жигд хөгжлийг хангах, хөрөнгө хүчээ төвлөрүүлэн эдийн засгаа бүсчлэн хөгжүүлэх төрийн бодлогыг тодорхойлсон.

Тус сум 2008-2022 он хүртэлх дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж ажиллаж ирсэн. Энэхүү хөтөлбөрийн зорилтууд Засаг дарга нарын хөтөлбөр болон жил бүрийн төлөвлөгөөнд тусгагдаж биелэлтийг хангаж байгаа боловч одоогийн нийгэм эдийн засгийн хөгжлийн хэрэгцээ шаардлагатай уялдуулж, төрийн бодлого шийдвэртэй уялдуулан олон нийтийн оролцоон дээр тулгуурлан, тооцоо судалгааг нарийвчлан гаргаж, шинэчлэн боловсруулах шаардлага тулгарч байна.

Тус сум нь 9 багтай, 8782 хүн амтай, 281880 толгой малтай, өндөр хүчдэлд холбогдсон. Казах, Тыва 2 үндэстэн амьдардаг. ОХУ, БНХАУ-уудыг Улаанбайшин-Даянгийн боомтоор холбосон олон улсын чанартай замын дагуу байрлалтай. Сумын төвд 800 гаруй өрхтэй, 3 сургууль, 2 цэцэрлэг, сум дундын эмнэлэг, соёлын төв, спорт цогцолбор зэрэг албан байгууллага, 50 гаруй аж ахуйн нэгж, 7 төрийн бус байгууллага, 100 гаруй хүнсний болон барааны дэлгүүр, улаан тоосгоны үйлдвэр үйл ажиллагаа явуулдаг. Кемелекийн гянт болдын уурхайд өндөр хүчдлийн шугам татаж, өргөтгөл хийгдсэн. Цаашид тус суманд хөдөө аж ахуй, уул уурхай, жижиг дунд үйлдвэрлэл, аялал жуулчлал хөгжүүлэх бүрэн боломжтой юм.

Цэнгэл сум 2014 онд “Сумын төвийн шинэчлэл төсөл”-д хамрагдсан. 2015 оноос эхлэн дулаан, цэвэр, бохир усны станцууд баригдах ба эдгээр бүтээн байгуулалтын ажил сумын ирээдүйг харсан байх үүднээс хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаж, сумын бодлогын хувьд уялдсан байх ёстой. Өөрөөр хэлбэл төрийн бодлого шийдвэр, улс, аймгийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй уялдуулан, орон нутгийн онцлог, давуу талд түшиглэсэн хөгжлийн хэтийн чиг хандлагыг оновчтой тодорхойлоход төлөвлөгөөний зорилго оршиж байна.

Эдгээр асуудлыг шийдвэрлэхэд нутгийн иргэдийн оролцоотойгоор, хэрэгцээнд суурилсан хөгжлийг төлөвлөх, бизнесийн таатай орчин бүрдүүлэх, орон

нутгийнхаа нөөц боломжид түшиглэн эдийн засгийн салбаруудыг хөгжүүлэх, өрсөлдөх чадвар, бүтээмжийг дээшлүүлэх, төр нийгмийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, байгаль орчныг хамгаалан нөөцийг нь зохистой ашиглах шинэ үзэл баримтлал, шинэлэг арга замаар хандах нь нэн шаардлагатай болж байна. Энэ үүднээс сумын хөгжлийн төлөвлөгөөг иргэдийн оролцоотойгоор төлөвлөх зорилт тавин ажиллав.

Сумын олон нийтийг оролцуулан олон удаагийн семинар, ярилцлага, уулзалт зохион байгуулж, одоогийн байдлаар суманд тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлон гаргав.

Цэнгэл суманд тулгамдаж буй асуудлууд:

1. Мал аж ахуйн үйлдвэрлэл эрчимжээгүй, бэлчээрийн усан хангамж муу, газар тариалан хөгжөөгүй;
2. Дэд бүтцийн хөгжил хангалтгүй, жижиг дунд үйлдвэрлэл хөгжөөгүй, ажилгүйдэл, ядуурал их;
3. Байгаль экологийн тэнцвэрт байдал алдагдаж, цөлжилт ихэссэн, аялал жуулчлал хөгжөөгүй;
4. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж хангалтгүй, иргэдийн ажиллаж, амьдрах таатай орчин нөхцөл бүрдээгүй;
5. Үндэсний цөөнхийн асуудал /Казах, Тыва/.

Эдгээр тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхийн тулд дараах зорилгуудыг дэвшүүлэн тавьсан болно. Үүнд:

1. Уламжлалт бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, усалгаатай газар тариаланг орон нутгийн нөөц боломжид тулгуурлан хослуулан хөгжүүлэх замаар иргэдийн амьжиргааг дээшлүүлэх;
2. Иргэдийн тав тухтай амьдрах орчин нөхцлийг бүрдүүлж, орчин үеийн техник технологийн шаардлагад нийцсэн дэд бүтцийг хөгжүүлэх;
3. Байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалж, аялал жуулчлалыг хөгжүүлэх;
4. Зөв дадал, зан үйл, эрүүл аж төрөх хэвшилтэй, соёл боловсролтой, амьдрах ухаантай иргэдийг төлөвшүүлэх;
5. Үндэсний цөөнхөө дэмжиж ажиллах.

Цэнгэл сумын эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл

- Хөдөө аж ахуйг уламжлалт ба эрчимжсэн хэв шинжийг хослуулан хөгжүүлэх;

- Дэд бүтцийн хөгжилдөө тулгуурлан жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- Байгалийн нөөц, баялгийг зүй зохистой ашиглах, өвөрмөц соёл, ёс заншлаа хадгалан хөгжүүлэх үндсэн дээр аялал жуулчлалыг хөгжүүлэх.

Боловсруулах үйл ажиллагаанд оролцож, дэмжлэг үзүүлсэн:

- Ажил хариуцсан төр, засгийн байгууллагын ажилтнууд;
- Иргэд, олон нийт, төрийн бус байгууллагын төлөөлөл.

1.2. Зохион байгуулалт ба зохицуулалтын арга хэмжээ

1.2.1. Ажлын хэсэг

Сумын Засаг даргын 2013 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/131 тоот захирамжаар “Сумын хөгжлийн төлөвлөгөө” боловсруулах ажлын хэсгийг сумын Засаг даргын орлогчоор ахлуулан 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж ажиллав.

1. Б.Аль-Хасен, Засаг даргын орлогч, ажлын хэсгийн ахлагч
2. Б.Ерболат, Засаг даргын Тамгын газрын дарга
3. Т.Насанбат,Тыва бага сургуулийн захирал
4. Х.Жексенбай, Руханият бүрэн дунд сургуулийн захирал
5. А.Алтынбек, Тэтгэвэр, тэмгэмж хариуцсан улсын байцаагч
6. С.Тилеубай, Байгаль орчны хяналтын улсын байцаагч
7. Э.Лаура, Иргэний танхимын зохицуулагч



Ажлын хэсгийн гишүүд олон удаа цуглан ажлын явц, үр дүн, цаашид хийгдэх ажлын талаар зөвшилцөн ярилцаж, шийдвэр гаргаж байв. Ажлын хэсэг нь судалгаа авах болон төлөвлөгөө боловсруулах ажлыг нэгдсэн чиг удирдлагаар ханган ажилласан болно.

1.2.2. Төлөвлөлт, хяналтын хороо

Сумын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах, үйл ажиллагаанд нь хяналт, үнэлгээ хийх зорилго бүхий Төлөвлөлт, хяналтын хороог Сумын ИТХТ-ийн 2013 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн А/23 тоот тогтоолоор дараах бүрэлдэхүүнтэй байгуулав. ТХХ-нд албан байгууллагын дарга, эрхлэгч, бизнес эрхлэгчид, багийн Засаг дарга, өндөр настан, залуучуудын төлөөлөл, аймаг, Улаанбаатар хот дах нутгийн зөвлөлийн гишүүд, сум орон нутагтаа олон жил ажиллаж, амьдарсан сумын хөгжилд саналаа нэмэрлэх нөлөө бүхий иргэд орсон болно.

Үүнд:

1. Б.Бадамцэцэг – ИТХ-ын дарга, ТХХ-ны дарга
2. Т.Ташкен - Засаг дарга
3. Б.Аль-Хасен – Засаг даргын орлогч
4. Б.Ерболат – Засаг даргын Тамгын газрын дарга
5. С.Серикгүл –Бүрэн дунд сургуулийн захирал
6. Т.Насанбат – Тыва бага сургуулийн захирал
7. Б.Жангир – Загаст нуур бага сургуулийн захирал
8. Х.Жексенбай – Руханият бүрэн дунд сургуулийн захирал
9. К.Сьез – Сум дундын эмнэлгийн эрхлэгч
10. И.Уазифа – 1-р цэцэрлэгийн эрхлэгч
11. Ө.Айнажай -2-р цэцэрлэгийн эрхлэгч
12. Ы.Күлтай – Соёлын төвийн эрхлэгч
13. Ж.Дунхбаяр – ИТХ-ын нарийн бичгийн дарга
14. К.Абай- Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Бизнесийн төлөөлөл
15. Х.Табигат – Төрийн сангийн төлөөлөгч
16. А.Алтынбек – Тэтгэвэр, тэтгэмж хариуцсан улсын байцаагч
17. Ц.Ганболд - Нийгмийн даатгалын улсын байцаагч
18. С.Тилеубай – БОХ-ын улсын байцаагч
19. Б.Көпберген –Татварын улсын байцаагч
20. Х.Муратбек- Мал эмнэлэг үржлийн тасгийн дарга

21. Ж.Буга – Мал эмнэлэг үржлийн тасгийн мэргэжилтэн
22. М.Ботагөз – Мал эмнэлэг үржлийн тасгийн мэргэжилтэн
23. Ш.Абил – ЗДТГ-ын ня-бо
24. Ш.Насихат – ЗДТГ-ын нярав
25. Р. Магзам – Ахмадын хорооны дарга
26. Б.Кенесбек- Газрын даамал
27. Х.Марат – Халамжийн мэргэжилтэн
28. Ж.Мейрамхан - Халамжийн мэргэжилтэн
29. Х.Соронзонболд- Нийгмийн бодлогын ажилтан
30. Ц.Октябрь – Иргэний бүртгэлийн мэргэжилтэн
31. Э.Лаура – Иргэний танхимын зохицуулагч
32. К.Ахбота – Хуулийн ажилтан
33. Б.Латиза – Бичиг хэргийн ажилтан
34. Х.Еркежан – Хэвлэл мэдээллийн төлөөлөгч
35. Ш.Зарыххан – 1-р багийн Засаг дарга
36. Б.Салауат – 2-р багийн Засаг дарга
37. Ж.Болатхан – 3-р багийн Засаг дарга
38. А.Батбаяр – 4-р багийн Засаг дарга
39. К.Кенжебек – 5-р багийн Засаг дарга
40. Х.Серикжан – 6-р багийн Засаг дарга
41. Ц.Амарсанаа – 7-р багийн Засаг дарга
42. Д.Ермек – 8-р багийн Засаг дарга
43. С.Бекет - 9-р багийн Засаг дарга
44. Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөлийн төлөөлөл
45. Баян-Өлгий аймаг дахь нутгийн зөвлөлийн төлөөлөл
46. Е.Олжас – Залуучуудын төлөөлөл
47. Е.Арман – Залуучуудын төлөөлөл
48. Т.Есенкелди - Оюутан, Залуучуудын Холбооны Тэргүүн
49. К.Нуршаш – Залуучуудын төлөөлөл

1.2.3. Төлөвлөгөөний төслийн хэлэлцүүлэг

Сумын эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан хөтөлбөр, төслүүдийг олон нийтээр хэлэлцүүлэх ажлыг 2014 оны 12 сарын 18-нд хийв. Энэ хэлэлцүүлгийн үеэр СХТ-г ямар арга замаар, яаж боловсруулсан, ямар материал

цуглуулж ашигласан, ямар хүмүүстэй уулзаж санал, бодлыг нь тусгасан, хэдэн хүн оролцсон зэрэг мэдээллийг танилцуулсны дараа СХТ-ний ерөнхий бүтэц, сумын тулгамдсан асуудлууд, алсын хараа, зорилго, зорилт, хөтөлбөр, төслүүдийн талаар танилцуулж хэлэлцүүлэв. Үүнд олон нийтийн төлөөлөл болох 100-гаад хүн оролцож, санал бодлоо илэрхийлэв.

Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг албан байгууллагын албан хаагчид болон сургуулийн сурагчдын дунд эсээ, гар зургийн уралдааныг “2024 оны Цэнгэл сумын дүр төрх” сэдвээр зохион байгуулсан ба үүнд нийт 64 хүн материал ирүүлж, тус тусад нь шалгаруулан шагнав. Уг уралдаанаас гарсан саналуудыг хөгжлийн төлөвлөгөөнд оруулсан болно.

Төлөвлөгөөг боловсруулахад баримталсан гол зарчмууд:

- Төлөвлөлтийн бүх шатанд олон нийтийн оролцооны аргыг ашиглах,
- Хүний болоод нийгмийн хөгжилд голлон суурилах,
- Эдийн засгийн өсөлт, ололтыг нийгэм, байгаль орчны нөхцөл байдалтай холбон тэнцвэржүүлэх,
- Хувийн хэвшлийн аж ахуйн хөгжлийг дэмжих,
- Төлөвлөгөөний боловсруулалт, хэрэгжилт, хяналт, үнэлгээнд төр, олон нийт, иргэд, аж ахуйн хэвшлийн оролцоо, үүргийг тодорхойлох, хангах,
- Орон нутгийн нөөц, боломжийг илүүтэй дайчлах,
- Орон нутагт тохирсон бизнес, жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих,
- Улс, аймаг, бүс нутгийн хэмжээний хөгжлийн үзэл баримтлал, хөтөлбөр, төсөлтэй уялдуулах зэрэг болно.

Хоёрдугаар бүлэг. СУМЫН ХӨГЖЛИЙН ОРЧНЫ ОДООГИЙН БАЙДАЛ

2.1. Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын танилцуулга

2.1.1. Сум байгуулагдсан түүх


1911 оноос өмнө буюу Манжийн ноёрхолын үед одоогийн Цэнгэл сумын цагаан, улаан (мончаг), хар гэсэн 3 соёны тыва үндэстнүүд Ховдын хязгаарын 7 хошуу урианхайн цэрэг, хамжлага байсан бол казах өрхүүд Шеруши Үкирдад харьяалагджээ. Манж Чин улсын ноёрхолыг түлхэн унагаасны дараа Алтайн урианхай, Шеруши Үкирда-гийн айл өрхүүд 1912 оноос Богд хаант Монголын тулгар төрд багтан орсны дотор одоогийн Цэнгэл сумын иргэдийн өвөг, дээдэс байв.

1921 оноос Тывагийн 3 хошууг 3 сум, казахын Үкирда нарт харьяалах айл өрхүүдийг 1923 оноос Шыбарайгыр, Шеруши гэсэн 2 хошуу болж, одоогийн Цэнгэл сумын нутагт амьдарч байсан казах иргэд Шеруши хошуунд харьяалагджээ. 1925 онд тыва 3 хошуу нийлэн Цэнгэл хайрхан сум болж, Чандмань уул аймагт, 1930 онд Шеруши хошууны харьяа Бахат, Санрау, Хурман сумд байгуулагдан мөн аймагт, 1932 оноос эдгээр сумд Ховд аймагт харьяалагдсан. Санрау, Хурман сумдын ардуудын ихэнх нь одоогийн Цэнгэл сумын нутагт амьдарч байв. 1938 онд овог, отгийн нэрээр байгуулагдсан сумд газар, усны нэрээр нэрлэгдэх болж, Цэнгэлхайрхан, Цагаан гол сум байгуулагдан Ховд аймагт, 1940 оны 8-р сараас Баян-Өлгий аймагт харьяалагджээ. 1952 оны 10-р сард Цэнгэлхайрхан, сумын нэрийг Цэнгэл болгожээ. 1963 онд Цэнгэл, Цагаан гол сумд нэгдэн Цэнгэл сум хэмээн нэрлэгдэж, 1972 оны АИХ-ын тэргүүлэгчдийн 158-р тогтоолоор сумын төвийг Хөшөөт гэж нэрлэсэн байна.

Сумын онцлог

- Тус сумд тыва, казах гэсэн 2 үндэстэн амьдардаг.
- Монгол улсын хамгийн баруун цэгт оршдог.
- Монгол-Алтайн өндөр уулын бүсэд оршдог.
- Хятад улстай хил залгадаг.
- Аялал жуулчлалын үзэсгэлэнт газар элбэг. Алтай Таван богд уг сумын нутагт байрладаг.
- Байгалийн цогцолборт газар болох Шивээтхайрхан, Цэнгэлхайрхан, Дөнгөрөг уул, Хотон, Хурган нуур болон Цагаан усны халуун рашаан энэ нутагт байдаг.
- Дэлхийд алдартай 20 км Потанины мөсөн гол Алтай Таван богдоос эхлэлтэй бөгөөд тус сумын нутаг дэвсгэрт оршдог.

2.1.2. Газар зүйн байршил, ан амьтан, газрын гадарга, цаг уур



Зураг №1. Цэнгэл сумын газарзүйн байршил

Цэнгэл нутгийн өлзий бүян нь магтаж баршгүй газар ус, бахдаж баршгүй гайхамшигтай онгон байгальд нь байдаг. Баян-Өлгий аймгийн баруун хэсэгт, Улаанбаатар хотоос 1800 орчим км.

Цэнгэл сум нь 646.3 мянган га талбай бүхий нутагтай, улсын хамгийн өндөрлөг газарт оршдог. Уул нурууд нь далайн түвшингээс дээш 3000 – 4374 м хүртэл үнэмлэхүй өндөртэй ба сумын төв болох Хөшөөт нь д.т.д 1800 м өндөрт, Х.Ө 48° 57', З.У 89° 45' солбилцолд оршдог (Зураг 1).

Цэнгэл сум эх орныхоо баруун хоймрыг эзэгнэн, БНХАУ, ОХУ-тай хил залган, гурван улсын хилийн уулзварт оршдог. Газар нутгийн хэмжээ нь баруунаас зүүн хүртэл 200 км, хойноос урд хязгаар хүртэл 300 гаруй км. Нийт газар нутгийн хэмжээ **646317 га**. Түүний 2743 га нь хадлан, 14750 га нь ой мод, бусад нь бэлчээр байдаг.



Зураг №2. Таван богд

(3628м), Их Түргэн (3507м), Баяны нуруу (3442 м) зэрэг тэргүүнээс нь үүл манан үл салах хөх сүмбэр оргилууд бий.



Зураг №3. Хотон, Хурган

Уул, нуруу: Сумын газар нутгийн 56.7 хувь нь Монгол Алтайн нурууны Улсын тусгай хамгаалалттай газарт хамрагдана. Ихэнх газар нь далайн түвшингээс 1800-2000 м ба түүнээс дээш өндөрлөгт оршдог, мөнхийн цас мөс бүхий царам, оргил, ноёлог уулс голлоно. Монгол улсын хамгийн өндөрт тооцогддог Таван богд (4374м), Тыва түмний шүтээн уул Цэнгэлхайрхан (3943 м), Өндөрхайрхан (3914 м), Битүү (3654м), Цагаанхайрхан

Ус: Алтайн нурууны мөнх цаст мөсөн оргилуудаас эх авдаг Цагаан ус, Рашаант, Хоромдог, Цагаан гол, Загастай, Их Хүйтэн, Их Бага Түргэн, Сумдайраг, Могойт, Хатуу, Хотон, Харганат зэрэг 10 гаруй голууд Монголын баруун хязгаарын гүрээ судас мэт салаалж, Ховд голд цутган, Хар Ус нуурыг зорьдог. Энэ бүхэн Цэнгэл сумын нутагт байгаа нь үнэнхүү бахархалтай. Тэнгэрээс

заяат, өлзий хутаг оршсон манай нутагт ариун тунгалаг толионд нь цаст сүмбэр уулс нүүрээ тольдсон гүн нуур олон байдаг. Орон даяар нэртэй Хурган, Хотон нуураас гадна Хоромдог, Хаг, Хар, Цагаан, Ногоон, Шар, Онхад гэхчлэн нэр бүхий олон нуур цөөрөм байдаг.


Хөрс, ургамал: Цэнгэл сум нь аймгийн хэмжээгээр ногоон хүрэм нөмөрсөн, ой мод бүхий цорын ганц нутаг гэж хэлж болно. Хурган, Хотон нуур буюу Сыргалын хөндий, Ховд голын ай саваар хар мод, гацуур, хуш, нарс, улиас, бургас, хус, хайлаас, яргай, улаан бургас, уулын эгц цавчим энгэр, хажуу бэлээр ба цөл газарт нь заг, харгана, арц, бут зэрэг тарчиг модноос гадна чацаргана, нохойн хошуу, тошлой, хад, улаалзгана зэрэг жимсний төгөл элбэгтэй. Ойн чөлөө, нуга, асга хад, голын хөвөө, рашаан булаг дагаж зэрлэг төмс, сонгино, хөмүүл, халиар, мангир, мөөг, зэрлэг сармис ургана.

Бэлчээрийн ургамал нь тарчиг чийрэг ч гэсэн шим тэжээл сайтай. Малын тарга хүчинд нэн таатай. Голын ай сав, чийглэг газруудад өлөн, зэгс, өрхөг, хурган чих, тарваган шийр, уулын хяр бэлээр хялгана, агь, ганга, бэд, таар өвс, шарилж шаваг, царван, ортууз, хамхуул зэрэг бэлчээрийн болон эмийн ургамал элбэгтэй. Ялангуяа алтан хундага, дэгэд, таван салаа, хурган засаа, царван, халгай зэрэг эмийн ургамлаар баян нутаг юм.

Ан амьтан: Ой мод, гол горхи, нуур цөөрөм ихтэй, үржил шим бүхий өгөөмөр нутагт ан амьтан, жигүүртэн шувууд элбэг байх нь аргагүй. Сыргалын хөндий, ойн чөлөө, уулын энгэрт баавгай, буга, гөрөөс, асга хад эгц цавчим уулын энгэрт аргал угалз, янгир ямаа идээшин нутаглана. Ирвэс, шилүүс, чоно, үнэг, хярс, нохой зээх, мануул, өмхий хүрэн, цагаан үен, тарвага, зурам, хэрэм, туулай мэтийн амьтадтай хаа сайгүй тааралдаж болно. Харин ховордсон булга, суусар мэтийн амьтад хаа нэгтээ үзэгдэнэ. Цэнгэлийн буянтай сайхан нутагт жигүүртэн шувуудын олон арван төрөл бий. Ялангуяа дэлхийд ховордсон, зарим орны “Улаан номонд” бичигдэж, байгалийн музейн үзмэр болсон хун, ангир, хойлог, бүргэд, ёл, начин, шонхор, шар шувуу, ууль олноор амьдардаг энэ нутгийг “байгалийн парк” хэмээн нэрлэвэл зүйд нийцэх биз. Цэнгэл сумын нутагт байдаг нуур цөөрөм, гол горхинд тул, цагаан загас, хайруус, шар загас, зэвэг, хадарана элбэгтэй. Сэрээ, тор, дэгээ хэрэглэлгүй, гараар загас шүүрэх горхиуд ч цөөнгүй. Могой, мэлхий, бах, хонин гүрвэл зэрэг мөлхөгч амьтад шавар намагтай газар, голын саваар амьдарна.


Уур амьсгалын нөхцөл: Тус сумын нутгаар жилийн дунджаар нэг өдөр 7-8 цаг нар гийгүүлэх боловч 12-р сард хамгийн бага 4-5 цаг, 7-р сард хамгийн

их 9-11 цаг нартай байна. Жилийн дундаж цацраг тус сумын нутгаар 115-120 ккал/см².




Зураг №4. Цэнгэл сумын агаарын дундаж хэм /сараар/

Тус сум нь мөнх цаст оройтой өндөр уул нуруунууд элбэг байдаг учраас өвөл урт үргэлжилдэг ба хахир хүйтэн байдаг. Хамгийн хүйтэн өдөр нь 40⁰с-аас дээш байдаг ба хамгийн халуун өдөр 30⁰с хүрэхгүй. Агаарын температурын дундаж -4⁰с, -8⁰с. Хүчтэй салхи 10м/сек-ээс доош, шороон шуурга 10м/сек-ээс доош, цасан шурга 10м/сек-ээс дээш байдаг. Салхины хамгийн их хурд 20м/сек-40м/сек, 15м/сек-ээс хүчтэй салхитай өдрийн тоо 70-80 хүрдэг. Нэгэнт салхи ихтэй болохоор хавар, намрын улиралд шороон шуурга шуурах тохиолдол олон. Жилийн 230-250 хоног нь цэлмэг, өвлийн улирал нь урт.



Зураг №5. Хур тунадасны хэмжээ

Хур тунадас: Жилд 250-300 мм унадаг. Цасан бүрхүүл нь 5 дугаар сарын 1-ээс ханзарч эхэлнэ. Дулаан улиралын хур тунадас 300мм-ээс доош ба хүйтэн улиралын хур тунадас 30 мм-ээс дээш байдаг (Зураг 5).



Агаарын чийгшил:

Аймгийн нутаг дэвсгэрийг чийг хангамжийн хувьд чийглэгдүү хүйтэн өндөр уулын мужад хамаарна. Хамгийн их чийгтэй улирал I дүгээр сард ажиглагдана.

Зураг №6. Агаарын дундаж харьцангуй чийгшил

2.1.3. Байгалийн баялаг, түүх дурсгалын болон үзэсгэлэнт газрууд

Сумын нутаг дэвсгэрт гол, горхи, булаг шанд, нуур цөөрөм зэрэг байгалийн ил усны нөөц ихтэй тул хадлан, бэлчээрийн талбайг усжуулах боломжтой.

Цэнгэл сум нь аймгийн хэмжээнд ой модтой гол нутагт тооцогддог. Ховд голын хөндий, Цагаан голын эхээр, Хурган, Хотон нуурын өмнө талаар ой хөвч байна. Хар мод, хуш, гацуур, нарс, хус бүргас, улиас, яргай хайлаас ургана. Шинэсэн ойг маш их хэмжээгээр огтолж замбараагүй ашигласнаас ургамалжилтын бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдөж, нөхөн ургалт муудаж байгаа тул цаашид ойн нөхөн сэргээлтийн ажил хийх нь нэн чухал юм.

Одоогоор Цэнгэл сумын Кемелек хэмээх газарт 5000 гаруй тонны нөөцтэй гянтболдын орд газраас жилд дунджаар 50-100 тонн вольфрам олборлож байна. Тус сумын нутагт төмөр, зэс, молибден, гянтболд, никель, хар тугалга, алт зэрэг ашигт малтмалын орд болон илрэл байгаа. Үүнээс гадна элс хайрга, барилгын болон шохойн чулууны илрэл ч бий. Цаашид эдгээр ашигт малтмалын нөөцийг нь гүнзгийрүүлэн судлах, хайгуул хийж ашиглах шаардлагатай.

Археологчид, түүхчдийн судалгаанаас үзэхэд Цэнгэл сумын нутагт нэн эрт үеэс уламжлагдан ирсэн булш, хиргисүүр, хөшөө дурсгал, хүн чулуу, түрэг бичээс зэрэг түүх дурсгалын үнэт зүйлс элбэг байгаа нь тус бүс нутагт аялал жуулчлалын бизнесийг хөгжүүлэх чухал хүчин зүйл мөн билээ.

2.2. Нутгийн удирдлагын зохион байгуулалт


Одоо тус сум нь 9 баг, 1820 өрх, 8782 хүн амтай, 281880 толгой малтай, аймгийн томоохон сумдын нэг болоод байна. Сумд казах, тыва иргэд суурьшин амьдардаг ба дийлэнх нь казах иргэд юм.

Сумын ИТХ, Засаг даргын Тамгын газар, Боловсролын 4 сургууль, хүн эмнэлэг, хүүхдийн 2 цэцэрлэг, соёлын төв зэрэг төсөвт байгууллагууд, хадгаламж зээлийн хоршоод, улаан тоосгоны үйлдвэр, арилжааны банкууд, даатгалын компанийн салбарууд, мал эмнэлэг, талх нарийн боовны болон худалдааны цэгүүд, гүүний фермер, автомашины засварын газрууд, оёдолын цех, үсчин, гоо сайхан, гуталчин, фото студиуд үйл ажиллагаа явуулдаг.

- Орон сууц, олон нийтийн бүс 345.8 га
- Үйлдвэрлэлийн бүс 100 га
- Ногоон байгууламж, амралт, аялал жуулчлалын бүс 10 га
- Хөдөө аж ахуйн бүс 117.5 га Одоогийн байдлаар 607 иргэн гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 48.2 га газар өмчилж авчээ.

2.2.1. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага

Монгол улсын Үндсэн хуулийн 59 дүгээр зүйлийн 2-т “Нутгийн өөрөө удирдах байгууллага бол тухайн нутаг дэвсгэрийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Багийн Иргэдийн Нийтийн Хурал, тухайн хурлын хуралдааны чөлөөт цагт түүний тэргүүлэгчид мөн” гэж заасны дагуу сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 27 төлөөлөгч, 7 тэргүүлэгчидтэй, 9 багийн Иргэдийн Нийтийн Хуралтайгаар ажиллаж байна. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэд Иргэний танхим 2013 оны 3-р сарын 5-ны өдөр байгуулагдаж тогтмол ажиллаж байна. Түүнчлэн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл зэрэг орон тооны бүс зөвлөлүүд тогтмол ажиллаж байна. /Зураг №7/




Зураг №7. Сумын нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын зохион байгуулалт

2.2.2. Нутгийн захиргаа

Сум, багийн нутаг дэвсгэрт төрийн удирдлагыг сум, багийн Засаг дарга нар хэрэгжүүлдэг. Монгол улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 1-д “ Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга нь тухайн нутаг дэвсгэрт төрийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засаг төрийн төлөөлөгч мөн” гэж тодорхойлжээ.

Сумын нутгийн удирдлага Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, баг гэсэн шатлалаас бүрдэх ба ИТХ орон тооны 2, ЗДТГ 22, баг 9 ажилтантай бөгөөд Тамгын газар, нутгийн захиргааны зардлыг орон нутгийн төсвөөс, боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллага улсын нэгдсэн төсвөөс, нийгмийн халамжийн ажилтан, татвар, нийгмийн даатгалын ажилтан, төслийн ажилтан зэрэг 7 хүн байгууллагын босоо тогтолцоогоор аймгийнхаа салбараас санхүүждэг.



Зураг №8. Сумын Засаг даргын Тамгын газрын бүтцийн бүдүүвч

Тус сум нь засаг захиргааны нэгжийн хувьд 9 багтай бөгөөд сумын Засаг даргын тамгын газрын удирдлага дор үйл ажиллагаагаа явуулдаг.

Хүснэгт №1.

Засаг захиргааны анхан шатны нэгж / 2013 оны байдлаар /

№	Багийн нэр	Өрхийн тоо	Хүн ам	Малын тоо	Сумын төвөөс алслагдсан зай /км/	Багийн Засаг дарга
1	Шар говь	194	890	33448	50	Ш.Зарыххан
2	Загаст нуур	154	680	27926	70	Б.Салауат
3	Цагаан Түнгэ	282	1357	50772	17	Ж.Болатхан
4	Хар уул	87	370	11573	70	А.Батбаяр

5	Бор бургас	267	1345	37915	15	К.Кенжебек
6	Уст тохой	242	1051	44104	15	Х.Серикжан
7	Долоон гаталга	123	516	14283	10	Ц.Амарсанаа
8	Партизан	235	1046	7922	Сумын төвд	Д.Ермек
9	Хөшөөт	236	1036	8479	Сумын төвд	С.Бекет
	ДҮН	1820	8291	236422		

Хөдөөгийн багууд багийн төвтэй, багийн холбоотой, бүх багийн дарга нар компьютерээр хангагдсан, Загаст нуурын багт бага сургууль бий.

2.3. Цэнгэл сумын чадавхийн үнэлгээ

Сумын хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний хэрэгжилтийг хэрхэн зохион байгуулж хэрэгжүүлж байгаагаас орон нутгийн эдийн засгийн хөгжлийн чадавхи хамаардаг. ОНХ-ийн чадавхийг олон нийтийн оролцоотойгоор ойр ойрхон үнэлж байх шаардлагатай бөгөөд энэ удаад уг үнэлгээг хийхдээ маркетингийн сурталчилгаа, хөрөнгө оруулагч нартай тогтоох холбоо, бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх, стратеги төлөвлөлтийн үйл явцыг дэмжих, ажиллах хүчнийг хөгжүүлэх, зөвлөгөө, мэдээллээр хангах, олон нийттэй харилцах зэрэг олон чухал үзүүлэлтүүдийг хамарсан асуулга бүхий хүснэгтийг ашигласан юм.

Цэнгэл сумын хөгжилд гүйцэтгэх үүргийн талаарх чадавхийн үнэлгээг сумын ТХХ-ны гишүүд, албан байгууллагын удирдлагууд, бизнес эрхлэгчид, иргэд, малчид, өндөр настангуудын төлөөлөл болсон 100 хүнээр тодорхойлуулж, дүгнэж үзвэл доорх дүн гарч байна.

Хүснэгт №2.

Сумын чадавхийн үнэлгээ

Д/д	Үүргүүд	1	2	3	4	5	Дундаж
1	Маркетинг	39	12	21	12	16	3.46
2	Хөрөнгө оруулагчтай холбоо тогтоох	43	23	12	13	9	3.78
3	Орон нутгийн бизнес эрхлэгч нартай холбоотой байх	12	45	23	18	2	3.47
4	Стратеги төлөвлөлтийн үйл явцыг дэмжих	13	22	38	20	7	3.14
5	Урамшуулал бий болгох санхүүжилт олгох	9	21	33	24	11	2.87
6	Ажиллах хүчний хөгжил	28	15	17	27	13	3.1
7	Эдийн засгийн хөгжлийн төслүүдийг бэлтгэх хянах	16	18	14	28	24	2.7

8	ОНЭЗХ-н төслүүдийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх	14	21	23	32	10	2.9
9	Засаг дарга болон Иргэдийн хурлыг зөвлөгөө мэдээллээр хангах	23	20	19	25	13	3.1
10	Эдийн засаг хөгжлийн асуудал хариуцсан төв байгууллагатай харилцаа тогтоон ажиллах	12	26	21	33	8	3
11	Мэдээллийн сан байгуулах	31	14	17	22	16	3.2
12	Үйл ажиллагаагаа тайлагнах	18	27	15	17	23	3
13	Олон нийтийн харилцаа	12	33	24	21	10	3.1

Тайлбар:

- 1 - маш бага чадавхитай, эсвэл тухайн үүрэг огт биелдэггүй.
- 2 - тухайн үүрэг маш бага түвшинд биелдэг.
- 3 - энэ чиглэлд хүчин чармайлт гаргаж байгаа, гэхдээ цаашид улам сайжруулах шаардлагатай.
- 4 - энэ үүрэгт хамаарах сумын чадавхи нь сайн.
- 5 - сум нь энэ үүргийг маш сайн биелүүлдэг, өндөр хөгжсөн чадавхитай.

Сумын чадавхийн үнэлгээг 100 иргэдээс авсан бөгөөд авсан үнэлгээнд дүгнэлт хийхэд үзүүлэлт болгон дээр тухайн үүрэг дунд түвшинд 2.7-3.8 баллын хооронд хэрэгждэг гэсэн үнэлгээ өгчээ. Дээр дурдсан үнэлгээний үр дүнд хөгжлийн төлөвлөгөө боловсруулахдаа сумын удирдлагын чадавхийг сайжруулах асуудлуудыг тусгах шаардлага гарч байна.

2.4. Эдийн засгийн үндсэн салбарууд

2.4.1. Мал аж ахуй

Сумын эдийн засгийн үндсэн салбар нь мал аж ахуй бөгөөд олон зууны тэртээгээс энэ нутагт малчин ардууд бэлчээрийн мал аж ахуй эрхэлж, баялаг туршлага хуримтлуулж ирсэн түүхтэй. Сумын дүнгээр 2014 оны эцэст 281880 мянган толгой мал тоолуулсны 0.1% нь тэмээ, 2.99 % нь адуу, 6.0 % нь үхэр, 43 % хонь, 48 % нь ямаан сүрэг байгаа юм.

Малчид бүлгийн зохион байгуулалтанд орж, хөдөлмөрөө хорших замаар бэлчээрийг бүлгээрээ эзэмшин хамтын ажиллагааны давуу талыг зөв ашиглах, бэлчээр нутгийг өнжөөж сэлгэн, улирлын хуваарьтай ашигладаг болоод байна.

Хүснэгт №3.

Мал аж ахуйн салбарын хөгжлийн үзүүлэлтүүдийн хандлага

Мал аж ахуйн салбар	2009	2010	2011	2012	2013
Малын нийт тоо					
Тэмээ	549	519	577	548	638
Адуу	6407	5735	6429	6612	7889
Үхэр	9323	8697	10790	10995	13274
Хонь	78844	71421	80081	83012	102419
Ямаа	90679	79358	97242	98195	112192

Сумын голлох салбар бол мал аж ахуй юм. Хонь болон ямаа бүх малын 80-аад хувийг эзэлдэг. Малын тоогоор аймагт тэргүүлдэг сум юм.

Мал эмнэлэг: Мал эмнэлэг үржлийн тасаг нь 3 мэргэжилтэн, 13 мал эмнэлгийн нэгжтэй үйл ажиллагаагаа явуулж байна. Мал эмнэлэг нь 1 фермер машин, 13 мотоцикльтой.

2.4.2. Газар тариалан

Тус сумд газар тариалангийн ажил эрхлэх боломж бага юм. Гэвч сүүлийн жилүүдийг авч үзвэл газар тариалан эрхлэлт өргөжиж байгаа нь харагдаж байна.

Хүснэгт № 4

Газар тариалангийн талбай, бүтээгдэхүүн үйлдвэрлэл

	Хэмжих нэгж	2009	2010	2011	2012	2013
Тариалсан талбай						
Төмс	Га	6,4	6,7	10,1	12	12,5
Хүнсний ногоо	Га	2,0	3,8	4,1	5	5
Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл						
Төмс	Тн	25,6	30,2	51	54	54
Хүнсний ногоо	Тн	10,9	8,6	21	24	24
Хадлан	Тн	5381	6100	7320	8910	10900

2.4.3. Жижиг, дунд үйлдвэрлэл

Цэвэр усны үйлдвэр, хэрчсэн гурлын 3 үйлдвэр, гүүний фермер, цагааны идээ, модон эдлэл, дархан, оёдол, суран эдлэл, мөхөөлдөс, талх нарийн боовны цехүүд, авто засварын газар тогтмол үйл ажиллагаагаа явуулж байна.

2.4.4. Аялал жуулчлал, үйлчилгээний бусад салбарын хөгжил

Суманд аялал жуулчлалын бааз байхгүй. Аймгийн аялал, жуулчлалын дотоод маршрутанд Алтай Таван богд уул, Хотон, Хурган нуур, Цагаан ус рашаан сувилал, Их бага Түргэний хүрхрээ, Сыргалы, Цагаан ус зэрэг үзэсгэлэнт газрууд хамрагддаг.

Хүн амын санхүүгийн үйлчилгээний эрэлт хэрэгцээг хангах боломж, нөхцөл сайжирч, одоогоор “ХААН”, “Төрийн” банкнаас гадна “Цэнгэл Хөгжил”, “Малчны хөгжил” зэрэг хадгаламж зээлийн хоршоод үйл ажиллагаа явуулж байгаа нь санхүүгийн зах зээлийн өрсөлдөөн зохих түвшинд хүрснийг үзүүлж байна.

Хүснэгт №5.

Бизнесийн нэгжийн тоо /2013 оны байдлаар/

	Бизнес эрхлэгчдийн төрөл	2009	2010	2011	2012	2013
1	Аж ахуйн нэгж байгууллага	47	49	54	60	62
1.1	Төрийн байгууллага	10	10	10	10	11
1.2	ХХК	10	12	14	16	16
1.3	Нөхөрлөл	1	1	1	1	1
1.4	Хоршоо	20	20	20	24	25
1.5	Төрийн бус байгууллага	3	3	6	6	6
1.6	Шашины байгууллага	3	3	3	3	3
2	Мал аж ахуй эрхлэгч	1528	1417	1507	1339	1370

2.4.5. Дэд бүтэц


Зам тээвэр: Аймгийн төвтэй холбогдох хоёр чиглэлийн зам бий. 1-р чиглэл нь Өлгий-Улаанхус-Цэнгэл, 2-р чиглэл нь Өлгий-Сагсай-Цэнгэл сум бөгөөд эдгээр нь шороон замаар холбогддог. Багууд нь сумын төвтэй мөн шороон замаар холбогддог. Сумын нутаг дэвсгэр дэх аялал жуулчлалын гол бүсийн замын чанар хангалтгүй юм. Улаанбайшинт болон Даянгийн боомтыг холбодог шороон зам

дайрдаг. Энэ жил Сумын төвийн шинэчлэл төслийн хүрээнд сумын төвд 800 м хатуу хучилттай зам, 1600 м явган хүний зам тавигдсан.


Эрчим хүч: Сумын төв төвлөрсөн эрчим хүчний сүлжээтэй холбогдсон тул эрчим хүчний эх үүсвэрийн найдвартай хангамжтай. Хөдөөгийн малчин өрхүүд сүүлийн жилүүдэд нарны цахилгаан үүсгүүр ашиглах явдал нэлээд өргөжсөн бөгөөд нийт малчин өрхийн 90 орчим хувь нь нарны цахилгаан үүсгүүртэй байна.

Холбоо: Сумын төвд автомат телефон станц, хөдөөгийн багуудын төвд радио холбоо ажилладагийн зэрэгцээ хэрэглэгчид Мобиком, Жи-Мобайл, Юнител, Скайтел компаний үүрэн телефоны үйлчилгээг хүртдэг. Сумын иргэд Монгол Улсын телевизийн бүх сувгаас гадна Казахстан, БНХАУ-ын зарим сувгуудаас мэдээлэл авах боломж бүрдсэн. Мөн Улаанбаатар хот болон Баян-Өлгий аймгаас явуулж буй радио өргөн нэвтрүүлгийн мэдээллийг өдөр бүр сонсох хэвшилтэй.

2.4.6. Хүний нөөц, амьжиргааны чадавх



Зураг № 9. Хүн амын ерөнхий үзүүлэлт




Зураг №10. Ажиллагчидын судалгаа

Сумын иргэдийн 75-85% нь мал аж ахуй эрхэлж байна. 2010 онд ажилгүйчүүдийн тоо нэмэгдсэн боловч ажилгүйчүүдийн тоо сүүлийн 3 жилд буурч эхэлжээ. 2013 онд ажиллагчидын 80%-ийг мал аж ахуй эрхлэгчид эзэлж, боловсрол, худалдаа үйлчилгээ, холбоо тээврийн салбарууд дараагийн голлох салбар болсон байна.

Хүснэгт №6.

Ажиллагчдын бүтэц, салбараар

	2009	2010	2011	2012	2013
Ажиллагсад, үйлдвэрлэлийн салбараар					
Мал аж ахуй	3245	3239	3221	3218	3201
Газар тариалан	23	23	24	28	26
Цахилгаан дулаан	34	36	36	38	43
Холбоо, тээвэр	28	29	27	29	30
Худалдаа үйлчилгээ	78	80	84	82	84
Төрийн байгууллага	24	23	24	24	25
Боловсрол	152	154	160	156	164
Эрүүл мэнд	32	31	31	34	36
Бусад	88	49	148	50	236
Ажилгүйчүүдийн тоо	109	586	286	218	196



Зураг № 11 Ядуу өрхийн судалгаа

2010 онд нийт өрхийн 30.6 хувийг ядуу өрхүүд эзэлж байсан бол 2013 он гэхэд 22% болон буурч ядуу өрхүүдийн амжиргаа сайжирсан байгааг харуулж байна.

2.4.7. Орон нутгийн төсөв

Хүснэгт №7.

Орон нутгийн төсөв /мянган төгрөг/

Төсөв	2009	2010	2011	2012	2013
Орон нутгийн төсвийн орлого	98463.8	135649.0	159404.1	242266.4	254175.7
Хүн амын орлогын албан татвар	57345.8	72653.7	100716.0	157861.4	182336.8
Бууны албан татвар	886.0	776.0	930.0	930.0	950.0
Ойн орлого	2791.0	5846.1	10209.5	9146.0	10350.0
Газрын төлбөр	3231.0	3916.1	4500.0	4000.0	5000.0
Ус ашигласны төлбөр	300.0	305.2	300.0	461.9	1136.0
Хүү торгууль	400.0	1032.0	1000.0	1700.0	2215.2
Бусад орлого	3328.3	4159.3	6921.1	6249.4	7924.5
Орон нутгийн төсвийн зарлага		178300.0	248582.0	343831.0	376326.0

2.5. Албан байгууллагын товч танилцуулга

2.5.1. Боловсролын салбар

Тус суманд ерөнхий боловсролын 4 сургууль ажиллаж, иргэдэд боловсролын үйлчилгээ үзүүлж байгаагаас гурав нь төрийн өмчийн, нэг нь хувийн хэвшлийнх юм. Үүнд:

- ❖ Бүрэн дунд сургууль,
- ❖ Тува бага сургууль,
- ❖ Загаст нуур бага сургууль,
- ❖ Руханият бүрэн дунд сургууль юм.

Ерөнхий боловсролын сургуулиудын 70 бүлэгт нийт 1933 хүүхэд суралцаж байна. Бага боловсролын хамран сургалт 88.1 хувь, суурь боловсролын хамран сургалт 88 хувьд хүрсэн. Мэргэжилтэй багш нарын хангалт 96.1 хувьтай байна.

Цэнгэл бүрэн дунд сургууль

Цэнгэлхайрхан сумын бага сургууль Раднаасэд, Гөлгөө гэсэн хоёр багштай, хоёр ангитай, 56 сурагчтай байгуулагдаж байсан бол Цагаан гол сумын бага сургууль Казахстанас уригдаж ирсэн багш Төлеубай Хордабаев, түүний гэргий Күлаш багш, мөн аймгаас томилогдсон Даривхан, түүний гэргий Шөрке багш нарын оролцоотойгоор гурван анги, 96 сурагчтай тус тус хичээлийн жилээ эхэлсэн түүхтэй билээ. Тухайн үед нутгийн гар урчуудын хүчээр хичээлийн танхим, гал тогоо, агуулах, халуун ус зэрэг зориулалтын дүнзэн байшинг барьж, ашиглан, сургалтын үйл ажиллагааг явуулжээ. Түүнчлэн, 1947 онд Борбургаст, 1967 онд Сыргалыд анхан шатны салбар бага сургуулиудыг шинээр нээж, хүмүүс олноор суурьшдаг нутаг руу ойртуулсан байна.

Харин бүх нийтийг бүрэн дунд боловсролтой болгох зорилттой уялдуулан тус суманд байсан бага сургуулиудыг нэгтгэн 1968-1969 оны хичээлийн жилд 8 жилийн сургууль болгон өргөжүүлжээ. Улмаар 1988-1989 оны хичээлийн жилээс эхлээд 10 жилийн сургууль боллоо.

1972-1973 хичээлийн жилээс 2 давхар бүхий 440 хүүхдийн суудалтай хичээлийн шинэ байранд хичээллэж эхлэв. Сумынхаа сургуулийн материаллаг нөхцөлийг сайжруулах үүднээс 1978-1981 онуудад 100 хүүхдийн багтаамж бүхий 3 дотуур байрны барилга ашиглалтанд оруулжээ. 1983 онд 320 хүүхдийн суудалтай хичээлийн байр, нэг ээлжинд 200 хүүхэд хооллох гал тогооны байр тус тус ашиглалтанд оров.



Зураг № 12. Цэнгэл бүрэн дунд сургууль

70 жилийн түүхтэй манай сургууль одоо захирал С.Серикгүл, нийгмийн ажилтан Р.Жанатхан, сургалтын менежерүүд А.Биржан, Д.Күлимаш, М.Жайнагүл нарын удирдах бүрэлдхүүн бүхий 1432 сурагч, 86 багштай, 63 ажилчинтай өнөр өтгөн хамт олон болж, сургалтын үйл ажиллагааг орчин үеийн өөрчлөлт шинэчлэлд уялдуулан явуулж, хөдөөгийн сургуулиудын дотор тэргүүн байрыг эзэлж байгаа юм.



Зураг №13. Дотуур байр

Тыва бага сургууль

Тыва бага сургууль нь үндэсний цөөнх болсон тывачуудын хэл, соёлыг хойч үедээ өвлүүлэн үлдээх, хадгалах зорилгоор 1991 онд тыва иргэдийн хүсэлтээр Баян – Өлгий аймгийн Ардын хурлын гүйцэтгэх захиргаанаас №147 дугаар тоот тогтоол гарч тыва хэлээр дунд боловсрол олгох 10 жилийн дунд сургууль нэртэйгээр байгуулагдаж 160 сурагч, 16 багш ажилтантай сургалт хүмүүжлийн ажлаа явуулж эхэлсэн.

Тэрээр 1997 онд Монгол улс даяар боловсролын салбарт бүтцийн өөрчлөлт хийгдэж 10 жилийн казах дунд сургуультай цогцолбор хэлбэрээр нэг хичээлийн жил үйл ажиллагаа явуулсан. Дараа нь дахин тыва иргэд хүсэлт гаргаж 10 жилийн дунд сургуулиас ажлын хэсэг гарч дүгнэлт гарган, уг дүгнэлтийн дагуу Сумын Засаг даргын 1998.09.10 – ны өдрийн №20 тоот дугаартай захирамж гарч бие даасан Тыва бага сургууль болон зохион байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна.

2013 – 2014 оны хичээлийн жилийн байдлаар Т.Насанбат захиралтай 12 багш, 1 сургалтын менежер, 21 ажилтантай, 173 сурагчтай, 9 бүлэгтэй, дотуур байранд 93 хүүхэдтэйгээр сургалт хүмүүжлийн ажлаа зохион байгуулан явуулж байна. Сурах бичгээр бүрэн хангагдсан, сургалтын орчин сайн.

Цаашид 320 хүүхдийн суудалтай хичээлийн стандарт шаардлага хангасан байр бариулахаар зорилт тавин ажиллаж байна.



Зураг №14. Тыва бага сургууль

Загаст нуур бага сургууль

1997 онд Загаст нуурын хичээлийн байр баригдаж, бага сургууль байгуулагдсан. Бага боловсрол олгох 5 жилийн сургууль 6 бүлэгт 108 хүүхэд суралцаж байгаа бөгөөд бага ангийн хамран сургалт 82 хувьтай, мэргэжилтэй багшийн хангалт 100 хувьтай байна.

Руханият бүрэн дунд сургууль

Руханият бүрэн дунд сургууль нь сум, орон нутгийн ирээдүй болсон хүүхэд багачуудад ерөнхий эрдмийн мэдлэгийг, ёс заншил, өв уламжлалтай хослуулан олгодог анхны сургууль юм. Руханият 12 жилийн сургууль нь 2006 оны 9 сарын 1-нээс үйл ажиллагаагаа эхлүүлсэн. 2012 онд Астана хот дахь “Алтын Қыран” нэгдсэн компаниудын ерөнхийлөгч Исламбек Салжановын тусламжтайгаар их засвар хийсэн 2 давхар 13 тасалгаатай сургууль, 1 давхар 16 тасалгаатай дотуур байртай. Нийт 6 анги 209 сурагчтай. Түүнээс 80 хүүхэд дотуур байранд байрладаг, 22 багш 10 ажилтан, 5000 гаруй шашин, эрдэм шинжилгээ, уран зохиол, түүхийн номын фондтой номын сан, компьютерээр бүрэн тоноглогдсон танхим, нэг доор 40 хүүхэд хооллох хоолны газартай. Суралцагчид орчин үетэй нийцсэн боловсрол олж, оюуны хүмүүжил эзэмших бүрэн боломжтой.

Хичээлийн хөтөлбөрийн 80% эрдэм шинжилгээ 20% оюуны чиглэлээр явагддаг. Ерөнхий хичээлүүдээс гадна шинэчлэгдсэн ба гүнзгийрүүлсэн хичээлүүд ордог. 2008 оноос хойш сурагчид төлбөргүй суралцдаг болсон.

Эх орны болон гадны байгууллагууд, буяны сангуудтай хамтарч ажилладаг. Төгсөгчдийг Арабын улсууд, Турк, Казакстан мөн эх орны шинжлэх ухааны болон шашны их дээд сургуулиудад гэрээгээр суралцуулж, мэргэжил эзэмшүүлж байна.



Зураг №15. Руханият бүрэн дунд сургууль

2.5.2. Сургуулийн өмнөх боловсрол

Хүүхдийн 1-р цэцэрлэг

1960 онд Цагаан гол сумын артелийн дэргэд, 1965 оны 3-р сарын 1 -нд “Алтайн оргил” нэгдлийн дэргэд 25 ортой хүүхдийн цэцэрлэг анх нээгджээ. 1978 онд зориулалтын байр, тоглоомын талбай, зуны бүлэг бүхий шинэ барилгад орж, 75 хүүхэдтэйгээр улсын мэдэлд шилжин ажиллажээ. И.Уазипа эрхлэгчтэй тус цэцэрлэгийн хамт олон одоо 7 бүлэгтэй, 32 багш ажилчинтай, 175 хүүхдийг өдрийн бүлгээр, зуны гэр цэцэрлэгээр 405 хүүхдийг, 48 хүүхдийг бэлтгэл бүлгээр хүүхдүүдтэй тус тус сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагааг явуулж байна. 2007 оноос 6 жил дараалан 1-р байранд шалгарсан. Казах, тыва үндэстний хүүхдийг зэрэг сургаж хүмүүжүүлэх онцлогтой.



Зураг №16. Хүүхдийн 1-р цэцэрлэг

Хүүхдийн 2 дугаар цэцэрлэг

Аймгийн Засаг даргын 2012 оны 09-р сарын 03-ны өдрийн №475 дугаар захирамжийн дагуу урьдчилан зөвшөөрөл авч, 1 дүгээр цэцэрлэгийн харъяагаар ажиллаж эхэлсэн. 2013 оны 01-р сарын 01 ний өдрөөс эхлэн “Цэнгэл сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэг” хэмээн нэртэй болж, № 0000197 дугаартай сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, өөрийн гэсэн төсөв, санхүүтэй болж, өдөр тутмын үйл ажиллагааг явуулж эхэлсэн юм. Ө.Айнажай эрхлэгчтэй тус цэцэрлэгийн хамт олон одоо 5 бүлэгтэй, 6 багш, 14 ажилчинтай ажиллаж байна.

2.5.3. Соёлын үйлчилгээ

1956 онд Соёлын төвийн барилга ашиглалтанд орсон. Тус барилгад урлагийн тоглолт, дугуйлан, номын сангийн үйлчилгээ, орон нутаг судлах танхим зэрэг соёл урлагийн бүх үйл ажиллагаа явагдаж байна. Сумын төвийн шинэчлэл төслийн хүрээнд тус суманд 2014 оноос шинэ Соёлын төв баригдаж эхэлж байна. Одоо Ы.Күлтай эрхлэгчтэй 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.



Зураг № 16. Соёлын төв

2.5.4. Эрүүл мэндийн үйлчилгээ

2012 онд шинэ эмнэлэгийн байртай болж, 30 ортой, К.Сьез эрхлэгчтэй, 41 эмч, ажилчидтай үйл ажиллагаагаа явуулж байна. Сумын төвийн эмнэлгээс гадна хөдөө улирлын чанартай ажилладаг 3 эмнэлэг байна.



Зураг №17. Сум дундын эрүүл мэндийн төв

2.6. Иргэд, оролцогч талуудын оролцооны үнэлгээний дүн

2.6.1. Бизнес орчны судалгааны дүгнэлтүүд

Бизнесийн орчныг сайжруулах хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажил манай суманд бизнес хөгжих орчныг тал бүрээс судлахаас эхэлсэн гэж хэлж болно. Сүүлийн 5 жилийн статистик мэдээ, олон нийтийн дунд явуулсан санал асуулгад тулгуурлан сумын эдийн засаг нийгмийн өнөөгийн түвшин, нөөц боломж, зах зээлд өрсөлдөх чадвар, саад бэрхшээлийг тодруулах зорилгын дор бизнесийн орчны судалгааг явуулав.

Нийтдээ 4 бүлэг, 25 асуулт бүхий санал асуулгаар малчид, бизнес эрхлэгч зэрэг 62 иргэнээс санал авснаас гадна сумын эдийн засгийн болон хүн ам зүй, хөдөлмөр эрхлэлт, байгаль цаг уурын өөрчлөлт, төсөв санхүүгийн эх үүсвэр зэрэг статистик үзүүлэлт, тоон мэдээ мэдээлэл болон бусад холбогдох материалыг цуглуулан судалж нэгтгэн дүн шинжилгээ хийснээр бизнесийн орчныг сайжруулах талаар төлөвлөгөөнд тусгагдах гол үндэслэл, дүгнэлтүүдийг гаргалаа.

Сумын эдийн засгийн өнөөгийн хөгжил болон ирээдүйн төсөөлөл, бизнес эрхлэхэд эерэг болон сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийг урьдаас олж харах, бизнесийн орчинг сайжруулахад шаардлагатай зохицуулалтыг тодруулах, бизнесийн орчинг сайжруулах талаар орон нутгийнхан юу хүсэж шаардаж байгаа талаар мэдээлэл цуглуулах, санаа бодлыг сонсоход судалгааны тодорхой хэсэг нь чиглэгдсэн болно.


Хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад орон нутгийн бизнес эрхлэгчдийн санал бодол, ирээдүйн төсөөллийг тусгасан явдал сумын эдийн засгийн хөгжлийн асуудлаар шийдвэр гаргах түвшинд нөлөөлөх томоохон хүчин зүйл боллоо гэж үзэж байна.

Бизнесийн орчныг сайжруулах мастер төлөвлөгөө боловсруулахын тулд сумын малчид бизнес эрхлэгчдээс сумын хөгжлийн одоогийн ба ирээдүйн байдлыг үнэн бодитой тогтоохын тулд ажил хэрэгч, бүтээлч, санаачлагатай гэгдэх хүмүүсээс судалгаа авлаа.

Судалгааны дүнг бизнесийн орчныг сайжруулах төлөвлөгөө боловсруулах баг болон нутгийн иргэдээр хэлэлцүүлж тэдний саналыг авлаа.


Судалгаанд оролцогчдын дотор өмчлөгч эзэн 41, менежер 5, бусад 5, ажилтан 11 оролцлоо. Үүнээс малчин 12, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч 16, газар тариалан эрхлэгч 7, худалдаа үйлчилгээ эрхлэгч 43 хүн багтаж байлаа. Судалгаанд хамрагдагчдын бизнес эрхэлсэн хугацааг авч үзэхэд 27.5% нь 3 хүртэл жил, 41.3% нь 3-10 жил, 31.2% нь 11 жилээс дээш жил ажилласан байна.

Бизнесийн төрлөөр авч үзвэл хамгийн олон хувь эзэлж буй худалдаа, үйлчилгээний бизнес эрхлэгчдийн туршлагыг авч үзвэл 74 % нь 5-аас дээш жил ажилласан байна. Энэ нь худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн бизнес эрхлэх туршлага сайтай байгааг илэрхийлэх бөгөөд худалдаа үйлчилгээний салбарыг дэмжснээр бизнесээ улам өргөжүүлэх бололцоотойг харуулж байгаа юм. Бизнес эрхлэгчдийн 89.9% нь 5 хүртэл, 10% нь 6-10, 0.1% нь 11-50 тооны ажиллагсадтай.



Зураг № 18. Бизнесийн эрхлэгчдийн төрөл ажилласан жилийн хамаарал


Бизнесийн хэтийн төлөвийн үнэлгээ. Сумын дүнгээр судалгаанд оролцогчдын 91.7% нь бизнесийнхээ ирээдүйг өөдрөг гэж үнэлсэн нь сумын нийт бизнес эрхлэгчдийн сэтгэл зүйн болон ирээдүйдээ итгэх итгэл сайн байгааг харуулсан нэгэн давуу тал гэж үзэх үндэслэлтэй. Мөн судалгаанд оролцогчдын 91.5% нь цаашид бизнесээ эрчимжүүлэх замаар улам өргөтгөнө гэж үзжээ.



Зураг №19. Бизнесийн ирээдүйг хэрхэн төсөөлж байна вэ?

Зураг № 20. Бизнесээ өргөтгөх бодолтой байна уу?

Бизнесийн өргөжилт. Судалгаанд хамрагдагсдын 91.5% нь өөрсдийн эрхэлж буй бизнесийн үйл ажиллагааг өргөжиж байгаа гэж үнэлсэн нь тус суманд бизнесийн үйл ажиллагаа ерөнхий хандлагаараа өргөжиж байгааг илэрхийлж байна. Манай суманд бизнес өргөжиж байгаа хэмээсэн үнэлгээ нь ийм төрлийн үйл ажиллагаа тоо хэмжээний болоод хангамжийн талаасаа тэлж байгаа гэсэн үг.




Зураг №21. Бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүнээ борлуулдаг зах зээл болон бизнесээ өргөжүүлэх төрөл

Бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүнээ борлуулдаг зах зээл. Тус сумын бизнес эрхлэгчдийн дийлэнх нь бүтээгдэхүүнээ сумандаа борлуулж байгаа нь мөнгөний урсгалыг гадагш алдахгүй орон нутагтаа барьж байхад эерэг нөлөөтэй боловч борлуулалтын зах зээл хумигдмал байгааг илэрхийлж байна. Судалгаанд оролцогчдын 70.9 хувь нь чанарыг сайжруулах, 45.1 % нь нэр төрлийг олшруулах, 24% хувь нь сав баглаа боодлыг сайжруулах, 30% нь үнэ бууруулах, 54% нь захиалагчаа зөв олох, 50% нь борлуулах цэгээ нэмэгдүүлэх, 40.3% нь борлуулалтын урамшуулал хэрэглэх, 30.6% нь сурталчилгаа нэмэгдүүлэх, 42.9% нь шинэ зах зээлд нэвтрэх замаар борлуулалтаа нэмэгдүүлэх шаардлагатай байна гэж санал дэвшүүлжээ. Жишээ болгон сумандаа бүтээгдэхүүн үйлчилгээгээ борлуулж буй бизнес эрхлэгчдийн бизнесээ өргөтгөх арга барилыг нь авч үзсэн болно. /Зураг 23/. Уг судалгаанаас үзэхэд тус сумын иргэд чанарыг эрхэмлэдэг болох нь харагдаж байна.



Зураг №22. Борлуулалтын нэмэгдүүлэх арга




Зураг №23. Бүтээгдэхүүн, үйлчилгээ борлуулж буй бизнес эрхлэгчдийн борлуулалтыг нэмэгдүүлэх арга


Шинээр бизнес эрхлэх болон өргөтгөхөд тохиолдож буй гол бэрхшээлүүд.

Бизнес эрхлэгчдийн хувьд хамгийн хүндрэлтэй бэрхшээлүүд нь хөрөнгө санхүүгийн дутагдал, санхүү-технологийн ба дэд бүтцийн асуудал болж байна. Судалгаанд хамрагдагсад зээлийн хүү өндөр, зах зээлээс алслагдсан, газар хүрэлцдэггүй, валютын ханш өссөн зэрэг бэрхшээл байгааг дурьдсан байна.

Иймд төлөвлөгөө боловсруулахдаа жижиг дунд үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх, банкны зээлийн нөхцлийг хөнгөвчлөх замаар бизнес эрхлэгчдийн санхүүгийн чадавхийг дээшлүүлэх асуудлыг тусгах шаардлагатай болж байна.




Зураг №24. Шинээр бизнес эрхлэх болон өргөтгөхөд тохиолдож буй гол бэрхшээл



Зураг №25. Сумын төр, захиргааны үйл ажиллагааны сөрөг нөлөө

Сумын захиргааны байгууллагаас бизнес эрхлэгчдэд дарамт үзүүлдэггүй боловч дүрэм, журам гаргаж үйл ажиллагаанд нь саад болдог явдал гардаг байна. Иймд зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцож, эдгээр асуудлуудыг гаргуулахгүй байх нь чухал юм.


Бизнесээ өргөтгөхөд нөхцөл бололцоо хэр байгаа талаарх судалгааны үр дүнд бизнес эрхлэгчдэд бизнесээ өргөтгөхийн тулд газрын хүрэлцээ дутмаг, инженерийн байгууламжууд цөөн байгааг, харин эрчим хүч, холбоо хангалттай байна гэж хариулсан бөгөөд санхүүгийн эх үүсвэр, түүхий эд материал, зам харилцаа холбооны бололцоо дутмаг байгааг судалгааны үр дүнгээс харж болно.



Зураг №26. Бизнесээ өргөтгөн хөгжүүлэх нөхцөл бололцооны үнэлгээ

Иймд бизнесменүүдэд газар олгох, эзэмшүүлэх чиглэлээр ажиллах, мөн тэдний санхүүгийн асуудлыг шийдэх үүднээс бага хүүтэй урт хугацааны зээл олгох, ахуйн үйлчилгээний төвлөрсөн цэгт төвлөрүүлэх зэрэг аргуудаар тэдний энэхүү асуудлуудыг шийдэж болох бизнесийн таатай орчин бүрдүүлэх боломжтой нь харагдаж байна.


Бизнес эрхлэгчдийн үр чадварыг дээшлүүлэхэд аль чиглэлийн сургалт, семинарын алийг нь гол гэж үзэж байна вэ гэсэн асуултанд ажиллагчдын чадавхи бэхжүүлэх, компьютертэй ажиллах урь чадвар, чанарын хяналтын сургалтуудыг зохион байгуулах шаардлагатай гэсэн үр дүн харагдаж байна.




Зураг № 27. Захиргаатай ажиллах хугацаа

Судалгааны үр дүнд бизнес эрхлэгчид Засаг захиргааны нэгжтэй ажиллаж буй дундаж хугацаа нь 28,3 өдөр байсан бөгөөд үүнийг судалгаанд хамрагдагсдын ихэнх хувь нь боломжийн хугацаа хэмээн үзсэн байна. Энэ нь Засаг захиргааны нэгж болон бизнес эрхлэгчдийн байнгын харилцаа холбоотой байдал болон бизнес эрхлэгчдэд чирэгдэл учруулдаггүй байдлыг харуулж байгаа юм.

Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд нөлөөлж буй нийгмийн үйлчилгээнүүдийг харуулсан бөгөөд өмнөх асуултын адил банк, санхүүгийн үйлчилгээ нь ихээр нөлөө үзүүлж буй нь харагдаж байна. Эрүүл мэнд, боловсролын тогтолцоо, цагдаагийн хамгаалалт зэрэг нь дараагийн гол асуудлууд юм. Иймд эдгээр үйлчилгээнүүдийг илүү их хүртээмжтэй болгох чиглэлээр бодлого боловсруулах нь зүйтэй юм.




Зураг №28. Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд нөлөөлж буй нийгмийн үйлчилгээнүүд




Зураг №29. Орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэхэд сумын төр, захиргаанаас хэрэгжүүлвэл зохих арга хэмжээнүүд

Бизнес эрхлэгчдийн үзэж буйгаар орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэхийн тулд нэн түрүүнд ажлын байр бий болгох, төрийн үйлчилгээг бэхжүүлэх хэрэгтэй гэж үзсэн бөгөөд үүний дараагаар бизнесийн мэдээллээр хангах, дэд бүтцийг сайжруулах, байгаль хамгааллыг сайжруулах зэрэг арга хэмжээнүүдийг жагсаасан байна.



Зураг № 30. Байгууллага, албан тушаалтантай хамтран ажиллах байдал

Зураг №30-аас харахад бизнес эрхлэгчид бүх албан тушаалтануудтай ялангуяа сумын засаг дарга ба орлогч дарга, багийн засаг дарга, ИТХ-ын дарга, Татварын байцаагч, ЗДТГ-ын ажилтануудтай түлхүү хамтран ажилладаг байна.




Зураг №31. Өнгөрсөн 5 жилийн бизнесийн орчны өөрчлөлт

Зураг №32. Сумын эдийн засгийн өнгөрсөн 5 жилийн байдлын үнэлгээ


Зураг №31, 32-оос харахад бизнес эрхлэгчдийн хувьд өнгөрсөн 5 жилд эдийн засгийн байдал таатай байсан бөгөөд бизнес орчны нөлөөлөл ч мөн адил сайжирсан байна гэж хариулсан байна. Иймд өнгөрсөн жилүүдэд бизнес орчныг

хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн бодлого үйл ажиллагаануудыг улам сайжруулж үргэлжлүүлэх нь зүйтэй юм.



Зураг №33. Сумынхаа эдийн засгийн хөгжлийг нэмэгдүүлэхэд таны оруулах хувь нэмэр

Сумынхаа эдийн засгийн хөгжлийг нэмэгдүүлэхэд бүтээгдэхүүн үйлчилгээний чанарыг сайжруулах, жижиг дунд үйлдвэрийг бий болгох боломж их гэдгийг харуулж байна.



Зураг №34. Ядуурлыг бууруулахад сум, орон нутгаас хийх ажлууд

Ажилгүйдэл, ядуурлыг бууруулахын тулд жижиг дунд үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжиж ажлын байр бий болгох, хувийн хэвшлийг дэмжих, МАА-н салбарт шинэ техник технологи нэвтрүүлэх хэрэгтэй гэж үзэж байна.

2.6.2. SWOT шинжилгээний дүгнэлтүүд

Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй бүхий л байгууллагуудад SWOT шинжилгээ хийлгэж дүгнүүлсэн ба сумын ерөнхий SWOT шинжилгээг хүснэгт 8-д нэгтгэн үзүүлэв.

Хүснэгт №8

Сумын SWOT шинжилгээний нэгдсэн дүн

ДАВУУ ТАЛ	СУЛ ТАЛ
1. Мал аж ахуй эрхлэх уламжлалт арвин туршлагатай	1. Дэд бүтэц хөгжөөгүй
2. Хүн амын тоо харьцангуй олон тул худалдаа үйлчилгээний боломжийн зах зээлтэй	2. Зах зээлээс алслагдсан
3. Аялал жуулчлал хөгжүүлэх өргөн уудам нутаг байгалийн үзэсгэлэнт, түүх дурсгалт газар, үндэсний өвөрмөц онцлогтой	3. Ажилгүйдэл, ядуурал, архидалт, залхуурал их.
4. Хөдөлмөрийн нөөц сайтай	4. Бэлчээрийн хомсдолтой
5. Өндөр хүчдлийн шугам болон үүрэн холбооны сүлжээнд холбогдсон	5. Жижиг дунд үйлдвэр хөгжөөгүй, дэвшилтэд технологи нэвтрээгүй.
6. Байгалийн нөөц баялаг, ашигт малтмалын нөөцтэй	6. Бэлчээрийн мал аж ахуй эрчимжээгүй, боловсруулах үйлдвэр хөгжөөгүй.
7. Малын тоогоор аймагтаа тэргүүлдэг	7. Малчид, бизнес эрхлэгчдийн эрсдэл даах чадвар сул
8. Эмчилгээний зориулалт бүхий халуун, хүйтэн рашаантай	8. Хилийн боомт улиралын шинж чанартай
9. Нэн ховор болон ховордсон ан амьтан, ургамал элбэг	9. Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө хэрэгждэггүй.
БОЛОМЖ	СААД БЭРХШЭЭЛ
1. Үндэсний онцлог, соёл уламжлалыг жуулчид ихээхэн сонирхдог.	1. Байгалийн эрс тэс уур амьсгалтай, мал аж ахуйн үйлдвэрлэл эрсдэлд өртөмтгий
2. Байгалийн ашигт малтмалын нөөц ихтэй.	2. Хилийн зурваст ойрхон газар, онцгой бүсийг ашиглах боломж хязгаарлагдмал
3. Төр засгаас хэрэгжүүлж буй хөтөлбөр болон гадаадын төсөл хөтөлбөрт хамрагддаг.	3. Газар нутгийн дийлэнх хэсэг нь тусгай хамгаалалтын бүсэд оршдог учраас аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж хязгаарлагдмал
4. Хоёр улстай хил залгаа, хилийн боомтод ойрхон.	4. Хүн, малын гоц халдварт өвчин гарах магадлалтай
5. Уугуул нутгийн иргэд, эрдэмтэд, бизнес эрхлэгчдийг нутгийн хөгжилд татан оролцуулах	5. Банкны зээлийн хугацаа нь богино, хүү нь өндөр, барьцаа хөрөнгө шаарддаг.
6. Хөдөөгийн зарим газарт үүрэн холбооны сүлжээ нэвтэрсэн, малчдын 90-ээд хувь нь нарны эрчим хүч ашигладаг.	

Хүснэгт №9.

ЦЭНГЭЛ СУМЫН SWOT ШИНЖИЛГЭЭНИЙ МАТРИЦ

Гадаад орчны	Боломж				Саад бэрхшээл						
<p>Гадаад орчны</p> <p>1. Мал аж ахуй эрхлэх уламжлалт арвин туршлагатай</p> <p>2. Хүн амын тоо харьцангуй олон тул худалдаа үйлчилгээний боломжийн зах зээлтэй</p> <p>3. Аялал жуулчлал хөгжүүлэх өргөн удам байгалийн үзэсгэлэнт болон түүх дурсгалт газар, үндэсний өвөрмөц онцлогтой</p>	1	2	3	4	5	6	1	2	3	4	
	Үндэсний онцлог, соёл уламжлалыг жүүлчид ихээхэн сонирхдог.	Байгалийн ашигт малтмалын нөөц ихтэй.	Төр засгаас хэрэгжүүлж буй хөтөлбөр болон гадаргын төсөл хөтөлбөрт хамрагдах.	Хөр улстай хил залгаа, хилийн боомтод ойрхон.	Үгүйл нутгийн иргэд, эрдэмтэд, бизнес эрхлэгчдийн нийтлэн нийтлэн татан оролцуулах	Хөдөөгийн зарим газарт үүрэг хариуцаж буй нэр хүндтэй мэргэжилтэн, мэргэжилтэн, мэргэжилтэн нь	Хүч, малын гол халдварт өвчин гарах магадлалтай	Байгалийн эрс тэс уур амьсгалтай, мал аж ахуйн үйлдвэрлэл эрсдэлтэй	Хилийн зурваст ойрхон мөн ихэнх нутаг нь тусгай хамгаалалттай газар, онцгой бүсийн ашиглах боломж хязгаралтай	Хүн, малын гол халдварт өвчин гарах магадлалтай	Банкны эзлэлийн хугацаа нь богино, хүү өндөр, борлуулалтын өнөөдөр шаардлага.
	✓		✓	✓							✓
Довуу гол											
Дотоод орчны											

SWOT шинжилгээний хослолын матриц

Давуу тал – Боломж / Дт-Бо /	Давуу тал – Саад бэрхшээл / Дт-Сб/	Сул тал – Боломж / Ст – Бо /	Сул тал-саад бэрхшээл / Ст-Сб /
Дт1-Бо3. Мал аж ахуй эрхлэх уламжлалт арвин туршлагатай тул гадаад дотоодын төсөл хөтөлбөрт хамрагдаж малаа улам чанаржуулах	Дт2-Сб4. Банкны зээлийн хүүг бууруулах чиглэлээр бодлогын түвшинд хамтран ажиллах	Ст1-Бо3. Дэд бүтэц хөгжүүлэх төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх	Ст2-Сб3. Хүн, малын өвчин гарахаас урьдчилан сэргийлж, эм, эмчилгээний эд зүйлсээр хангах
Дт2-Бо4. Хилийн боомтод ойрхон тул худалдаа үйлчилгээг өргөжүүлэх	Дт7-Сб1. Байгалийн эрс тэс уур амьсгалд тохирсон мал аж ахуйг хөгжүүлэх	Ст2-Бо1. Зах зээлээс алслагдсан боловч аялал жуулчлалыг хөгжүүлэх бүрэн боломжтой	Ст2-Сб4. Банкны өрдөлдөх чадварыг нэмэгдүүлэх /Бүх банкны салбарыг байгуулах/
Дт3-Бо1. Үндэсний онцлог, соёл уламжлал болон түүх дурсгалын, үзэсгэлэнт газруудад түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлэх	Дт7-Сб3. Малын аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах	Ст3-Бо3. Ажилгүйдэл, ядуурал, архидалт, залхуурлаас гаргах сургалт зохион байгуулж, төсөл хөтөлбөрт хамруулах	Ст5-Сб1. Мал аж ахуйн үйлдвэрийг хөгжүүлэх
Дт3-Бо3. Аялал жуулчлалыг хөгжүүлэхэд төсөл хэрэгжүүлэх	Дт8-Сб1. Халуун, хүйтэн рашааныг улирлын чанартай ажиллуулах	Ст4-Бо2. Байгалийн нөөц баялагт түшиглэн ЖДҮ-г хөгжүүлэх	Ст6-Сб4. Малчид, бизнес эрхлэгчдэд бага хүүтэй зээл олгох боломж бүрдүүлэх
Дт5-Бо6. Хөдөөний малчдыг үүрэн холбооны сүлжээнд 100% холбох		Ст4-Бо3. Нутгийн уугуул УИХ-ын гишүүд, эрдэмтэд, мэргэжилтнүүдийг ЖДҮ болон дэвшилтэд технологиудыг нэвтрүүлэхэд татан оролцуулах, тэднээс дэмжлэг авах	
Дт6-Бо2. Байгалийн баялаг, ашигт малтмалыг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх		Ст6-Бо3. Малчид, бизнесменүүдэд эрсдэл даах сургалт, семинар явуулах	
Дт8-Бо1. Рашаан, сувилалын газрыг улсын хэмжээнд хөгжүүлэх, сурталчлан таниулах		Ст7-Бо4. Хилийн боомтыг тогтмол ажиллуулах	
Дт9-Бо3. Нэн ховордсон ургамал, амьтануудаа төсөл хөтөлбөр хэрэгжүүлж хамгаалах		Ст8-Бо3. Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх	

2.6.3. Сумын тулгамдсан гол асуудлуудыг “Асуудлын мод”-ны аргаар тодорхойлсон байдал

Сумын хэмжээнд тулгамдаж буй асуудлуудыг иргэдийн оролцоотойгоор, өөрсдөөр нь “Асуудлын мод”-ны аргаар тодорхойлуулсан. Үүнд давхардсан тоогоор 306 иргэн оролцов. Тэдгээрийн үнэлгээгээр гарсан олон саналыг бүлэглэн авч үзвэл дараах гол гол асуудлууд гарч ирсэн байна. Үүнд:

Цэнгэл сумын тулгамдаж буй асуудлууд:

1. Мал аж ахуйн үйлдвэрлэл эрчимжээгүй, бэлчээрийн усан хангамж муу, газар тариалан орхигдсон,
2. Дэд бүтцийн хөгжил хангалтгүй, жижиг дунд үйлдвэрлэл хөгжөөгүй, ажилгүйдэл, ядуурал их,
3. Байгаль экологийн тэнцвэрт байдал алдагдаж, цөлжилт ихэссэн, аялал жуулчлал хөгжөөгүй,
4. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж хангалтгүй, иргэдийн ажиллаж, амьдрах таатай орчин нөхцөл бүрдээгүй,
5. Үндэсний цөөнхийн асуудал /Казах, Тыва/.

Хүснэгт №11.

Сумын хөгжлийн тулгамдсан гол асуудлуудыг “Асуудлын мод”-ны аргаар тодорхойлсон байдал

№	Гол асуудал	Үр дагавар	Шалтгаан
1	Мал аж ахуйн үйлдвэрлэл эрчимжээгүй, газар тариалан орхигдсон, бэлчээрийн усан хангамж муу	-Малчин өрхийн орлого буурах -Малын хорогдол ихсэх -Бэлчээрийн даац хэтрэх -Бэлчээр хомсдох -Газар, хөрсний эвдрэл ихсэх -Биологийн төрөл зүйл устгах	-Цаг агаарын өөрчлөлт, хуурайшилт -Мал сүргийн бүтэц алдагдсан, тоо толгой хэт өссөн -Ашигласан газарт нөхөн сэргээлт хийгддэггүй -Хадлангийн талбай хомс
2	Дэд бүтцийн хөгжил хангалтгүй, жижиг дунд үйлдвэрлэл хөгжөөгүй, ажилгүйдэл, ядуурал их	-Жижиг дунд үйлдвэрлэл хөгжихгүй байх -Үйлдвэрлэлийн бүтээмж багасах, бараа бүтээгдэхүүний өртөг өсөх -Санхүүгийн эх үүсвэр дутагдах -Ажилгүйдэл, ядуурал, архидалт ихсэх -Өрхийн орлого буурах -Чадварлаг боловсон хүчнээ алдах -Осол аваар их гарах -Стандартын дагуу баригдаагүй барилга байгууламж сумын төвийн үзэмжийг алдагдуулах	-Зах зээлээс хол -Бизнесийн орчин бүрдээгүй -Туршлага дутмаг -Мэргэжлийн боловсон хүчин дутмаг -Шинэ техник технологи нэвтрээгүй -Банкны зээлийн хүү өндөр -Ажилчдын цалин бага -Ажлын байр дутмаг -Иргэдийн эрүүл, цэвэр орчинд амьдрах нөхцөл алдагдах -Машины зогсоол, замын хөдөлгөөний тэмдэг, автомашины зам, явган хүний зам байхгүй -Нэгдсэн худалдааны төв, нийтийн орон сууц байхгүй

			<ul style="list-style-type: none"> -Ногоон байгууламж байхгүй -Улсын хөрөнгө оруулалтаар баригдсан байгууллага цөөн -Замбараагүй газар олголт
3	Байгаль экологийн тэнцвэрт байдал алдагдсан, цөлжилт ихэссэн, аялал жуулчлал хөгжөөгүй	<ul style="list-style-type: none"> -Байгаль орчинд сэрэг нөлөө үзүүлэх -Хүн, мал усны гачигдалд орох -Байгалийн унаган төрхийг алдагдуулах -Иргэдийн эрүүл, цэвэр орчинд амьдрах нөхцөл алдагдах -Орон нутаг, иргэдийн орлого багасах 	<ul style="list-style-type: none"> -Булаг, шандны ус багасаж байгаа -Байгальтай зүй зохистой харьцах талаар иргэдийн мэдлэг хангалтгүй -Сумын төв орчмын хогийн цэгийн талбай тэлсэн -Аялал, жуулчлал хөгжөөгүй
4	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж хангалтгүй, иргэдийн ажиллаж, амьдрах таатай орчин нөхцөл бүрдээгүй	<ul style="list-style-type: none"> -Чанаргүй боловсон хүчин бэлтгэгдэх -Залуучуудын бичиг үсгийн боловсрол муудах -Бага насны хүүхдүүд хичээлдээ явах, харихад саад бэрхшээлтэй байна /Жич: нохой, оройтох/ -Үзэгчдийн тоо буурах -Ардын авьяастануудыг дэмжих, дугуйлан явуулах боломжгүй болох -Стандартын шаардлага хангасан номын сан ажиллуулах боломж бүрдэхгүй байх -Тоног төхөөрөмжийн хангамж муу -Орон Нутаг Судлах танхимыг ажиллуулах бололцоо муу байх -Иргэд эдийн засаг, цаг хугацаа, эрүүл мэндээр хохирох -Малын хулгай, архидалт -Багшлах боловсон хүчний чадвар хангалтгүй -Сургууль завсардалт их -Сургалтын чанар дутмаг -Оношлогооны тоног төхөөрөмж, мэргэжилтэн дутмаг -Залуусын хүмүүжил, төлөвшил доройтох -Албан хаагчдын ажиллах нөхцөл муудах --Төрийн алба биш төрлийн алба болох - Монгол хэлний мэдлэг сул - Хүүхдүүд цэцэрлэгт бүрэн хамрагдаж чадахгүй байх -Хүүхдүүд хөгжихгүй байх -Эрүүл мэндээр хохирох 	<ul style="list-style-type: none"> -Сургуулийн байр болон дотуур байр хуучирсан -Сургалтын орчин болон дотуур байр эрүүл ахуйн болон стандартын шаардлага хангахгүй байна -Айл өрх ихээр төвлөрсөн газруудад бага сургууль байхгүй байна -Багшлах боловсон хүчний чадвар сул -Сургууль завсардалт их -Сургалтын чанар тааруу -Соёлын төвийн барилга стандартын шаардлага хангахгүй, хуучирсан, ашиглах боломжгүй -Оношлогооны тоног төхөөрөмж, мэргэжилтэн дутмаг -Залуусын хүмүүжил, төлөвшил доройтох -Албан хаагчдын ажиллах нөхцөл муудах -Иргэд үйлчилгээ авахад хүндрэлтэй -Арьсны өвчлөл ихсэх, иргэдийн эрүүл мэнд, соёлд эерэгээр нөлөөлөх спортын арга хэмжээ бага зохиогддог -Орон нутаг судлах танхим, гэгээрлийн төв тогтмол ажилладаггүй -Ахуйн үйлчилгээний болон халуун усны газаргүй -СӨБ болон сургуулийн сургалтын систем уялдаа холбоогүй -Интернетгүй -Төрийн албан хаагчдын Монгол хэлний мэдлэг тааруу - Цэцэрлэгийн орон байр хүрэлцэхгүй -Дуу хөгжимийн танхим, багшийн хөгжлийн танхим байхгүй -Гүний худаг байхгүй -Гал тогоо анги танхим хамт байрласан -Хүүхдийн номын сан, тоглоомын талбай байхгүй
5	Үндэсний цөөнхийн асуудал /Казах, Тыва/	<ul style="list-style-type: none"> -Сурлагын хоцрогдол -СӨБ-д бүрэн хамрагдаж чадахгүй байна - Ном хүрэлцэхгүй, орчуулахад хүндрэлтэй 	<ul style="list-style-type: none"> -Тохирсон сурах бичиг байхгүй -Тыва хүүхдүүдийн цэцэрлэг байхгүй

2.6.4. Сумын хөгжлийн гол зорилгыг “Шийдлийн мод”-ны аргаар тодорхойлсон байдал

Хүснэгт №12

№	Гол зорилго	Үр дүн	Хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Уламжлалт бэлчээрийн Болон эрчимжсэн мал аж ахуй, усалгаатай газар тариаланг орон нутгийн нөөц боломжид тулгуурлан хослуулан хөгжүүлэх замаар иргэдийн амьжиргааг дээшлүүлэх	-Бэлчээрийн маргаангүй болно -Малын чанар сайжирч, нэг малаас авах ашиг шим нэмэгдэнэ -Малчдын орлого нэмэгдэж, ядуурал буурч, гэмт хэрэг зөрчил арилна	-Мах, сүүний чиглэлийн аж ахуйг эрхлэгчдийг дэмжих -Эрсдэлээс хамгаалах сумын тэжээлийн сан байгуулах -Ямааны тоог цөөрүүлж, малын тоог бэлчээрийн даацад тохируулах. -Сүргийн бүтцийг зохистой хэмжээнд байлгах -Малчдыг эрчимжсэн мал аж ахуй эрхлэх арга ажиллагаанд сургах -Орон нутгийн байгаль цаг уурт тохирсон ашиг шим өндөртэй хээлтүүлэгч, хээлтэгчийг гаднаас авах, бойжуулах -Малын үржлийн ажил үйлчилгээг технологийн дагуу явуулах. -Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг засварлуулах, шинээр гаргах -Байгальтайгаа зөв зохистой харьцах сэтгэлгээг хүн бүрт төлөвшүүлэх
2	Иргэдийн тав тухтай амьдрах орчин нөхцлийг бүрдүүлж, орчин үеийн техник технологийн шаардлагад нийцсэн дэд бүтцийг хөгжүүлэх	-Ажлын байр нэмэгдэнэ -Өрхийн орлого өснө -Өрсөлдөөн бий болно -Амьдрах орчин сайжирна -Ажилгүйдэл буурна -Архидалт багасна -Дундаж наслалт нэмэгдэнэ -Амьдрах таатай орчин бүрдэнэ -Осол аваар багасна -Ногоон байгууламжтай болно -Ахуй үйлчилгээний болон нэгдсэн худалдааны төвтэй, нийтийн орон сууцтай болно.	-Байгалийн баялагаа ашиглах -Зах зээлийн судалгаа хийх -Иргэдийн хандлагыг өөрчлөх, сургалт явуулах -Суманд үйл ажиллагаа явуулах банкны тоог олшруулах. -Намчирхах үзэл, хээл хахуулыг бууруулах -Автомашин болон явган хүний зам, машин зогсоол, таних тэмдэг тавих -Нэгдсэн худалдааны болон Ахуй үйлчилгээний төв барих -Нийтийн орон сууц барих -Айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгжүүд мод тарих, зүлэгжүүлэх -Айл өрхийг хаяг, дугаартай болгох, хашааг нэгдсэн загвартай болгох -Хогийн сав байрлуулах, гудамжийг гэрэлтүүлэх
3	Байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалж, аялал жуулчлалыг хөгжүүлэх	-Булаг шандны эхийг хамгаалах, ойжуулах, усан хангамжыг сайжруулна. -Байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил буурч, иргэд байгалийн дагалт баялагийг зөв ашиглах мэдлэгтэй болно. -Малчид, иргэдийн орлого нэмэгдэх, ажлын байр бий болно. -Байгальтайгаа зөв зохистой харьцана.	-Булаг шандны эхийг хамгаалах, ойжуулах -Байгаль орчны хог хаягдлыг цэвэршүүлж, хогийн төвлөрсөн цэгт шинэ технологи нэвтрүүлэх -Байгаль, экологийн танхим байгуулах -Сум орон нутагт хөгжүүлэх бололцоотой аялал жуулчлалын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх -Аялал жуулчлалын бааз, амралтын газар байгуулах -Тусгай хамгаалалтай газрын бүсэд ААНэгжүүдэд үйл ажиллагаа явуулах

		сэтгэлгээг хүн бүрт төлөвшүүлнэ.	боломж бүрдүүлэх - Байгалийн болон түүх дурсгалын үнэт зүйлсийг хашиж хамгаалах
4	Зөв дадал, зан үйл, эрүүл аж төрөх хэвшилтэй, соёл боловсролтой, амьдрах ухаантай иргэдийг төлөвшүүлэх	-Сургалтын таатай орчин бүрдэнэ. -Ажлын байр бий болно. -Сургалтын чанар сайжирч, чанартай боловсон хүчин бэлтгэх нөхцөл бүрдэнэ. -Иргэдийн боловсролын талаар бодит судалгаатай болж, бичиг үсгийн боловсрол олгоно. -Бага насны хүүхдүүд сурах таатай орчин бүрдэнэ. -Орон нутаг судлалын танхим болон номын сангаар бүрэн үйлчлүүлэх боломж бүрдэнэ -Соёлын үйлчилгээг тав тухтай орчинд хүртэнэ. -Соёлын үйлчилгээнд иргэдийн хамрагдал нэмэгдэнэ. /суудлын тоо нэмэгдэх/ -Иргэдэд хүрэх эмнэлгийн үйлчилгээ ойртон, чанартай болно. -Иргэдийн эрүүл мэндийн талаарх мэдлэг сайжрах, өвчлөл багасна. -Залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлдэг болох, мэдлэг боловсрол нь дээшлэнэ. -Ахуйн үйлчилгээг иргэд ойроос авдаг болж, зардал хэмнэнэ. -Ажлын байр нэмэгдэх, өрхийн орлого өснө. -Хүүхэд бүрийг хөгжүүлэх боломж бүрдэнэ - Хүүхдийн насанд тохирсон хоол хүнсээр хангана. - Цэвэр усаар хангагдана -Хүүхдүүд бүрэн хамрагдана	--Хичээлийн шинэ байрыг ашиглалтанд оруулж, ширээ, сандлыг шинэчлэх -Дотуур байрны хатуу, зөөлөн эдлэлийг шинэчлэх, засварлах -Дээд доод гудамд шинээр бага сургууль барих -Багш нарын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх -Өрх, хүн амын боловсролын түвшинг тогтоож, бодит судалгаатай болох -Албан ба албан бус сургалтанд хүүхэд, залуусыг бүрэн хамруулах -Стандартын шаардлага хангасан соёлын төв барих -Сумын эмнэлэгийг зайлшгүй шаардлагатай тоног, төхөөрөмжөөр бүрэн хангах -Эмч, эмнэлгийн ажилтны тоог стандартын хэмжээнд хүргэх, мэргэжлийг нь дээшлүүлэх -Залуучуудын дунд урлаг спорт, хууль тогтоомж сурталчлах ажлыг төлөвлөгөөтэй тасралтгүй зохион байгуулах -Иргэний танхимын тасралтгүй ажиллагааг хангах -Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх эргүүл, нөхөрлөл байгуулах -Ахуйн үйлчилгээний байртай болж, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх -Халуун усны барилга шинээр барьж байнга ажиллуулах -Намчирхах үзэл бодлоос ангижруулах сургалт зохион байгуулах -Төрийн албан хаагчдын Монгол хэлний мэдлэгийг дээшлүүлэх -Шинээр цэцэрлэг барих -Дуу хөгжмийн болон багшийн хөгжлийн танхим байгуулах - Интернет тавиулах -Гүний худагтай болох -Цэцэрлэгийн гал тогоог тусгаарлах -Хүүхдийн номын сан, тоглоомын талбай байгуулах
5	Үндэсний цөөнхөө дэмжиж ажиллах	-тыва иргэд тав тухтай амьдрах нөхцөл бүрдэнэ.	- Тыва сургууль, цэцэрлэг шинээр барих -Тыва бага сургуулийг 12 жилийн сургууль болгох -Сурах бичиг зохиох багийг дэмжих, хэвлэлтэнд дэмжлэг үзүүлэх

Гуравдугаар бүлэг. СУМЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

3.1. Хөгжлийн алсын хараа, сумын хөгжлийн тэргүүлэх чиглэл

АЛСЫН ХАРАА

Эрүүл, боловсролтой, соёлтой, ажил орлоготой, эх байгалиа дээдэлсэн иргэд бүхий эдийн засгийн хөгжлийн өөрийн гэсэн суурьтай, ажиллаж амьдрах таатай орчин бүрдсэн Монгол Улсын жишиг сум болно.

Сумын хөгжилд, тэргүүлэх чиглэл:

- Хөдөө аж ахуйг уламжлалт ба эрчимжсэн хэв шинжийг хослуулан хөгжүүлэх;
- Дэд бүтцийн хөгжилдөө тулгуурлан жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- Байгалийн нөөц, баялгийг зүй зохистой ашиглах, өвөрмөц соёл, ёс заншлаа хадгалан хөгжүүлэх үндсэн дээр аялал жуулчлалыг хөгжүүлэх.

3.2. Сумын хөгжлийн төлөвлөгөөний үндсэн чиглэлийг хангах зорилго, зорилтууд

Хүснэгт №13

Сумын хөгжлийн төлөвлөгөөний үндсэн чиглэлийг хангах зорилго, зорилтууд

Д/д	Зорилго	Д/д	Зорилтууд
1.	Уламжлалт бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, усалгаатай газар тариаланг орон нутгийн нөөц боломжид тулгуурлан хослуулан хөгжүүлэх замаар иргэдийн амьжиргааг дээшлүүлэх	1.1	Цаг уурт тохирсон ашиг шим өндөр хээлтүүлэгч, хээлтэгчийг гаднаас авах, мал сүргийн ашиг шим, таваарлаг чанарыг дээшлүүлэн сүргийн бүтцийг сайжруулах
		1.2	МАА-н материаллаг баазыг бэхжүүлж, байгалийн гамшиг эрсдэлийг давах чадварыг нэмэгдүүлэх
		1.3	Мал эмнэлэгийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж мал сүргийг эрүүлжүүлэх.
		1.4	Газар тариалангийн усалгаатай талбайг нэмэгдүүлж, сумын хүн амыг төмс, хүнсний ногооны хэрэгцээг өөрийн бүтээгдэхүүнээр хангах
2.	Иргэдийн тав тухтай амьдрах орчин нөхцлийг бүрдүүлж, орчин үеийн техник технологийн шаардлагад нийцсэн дэд бүтцийг хөгжүүлэх	2.1	Сумын төвийн ерөнхий төлөвлөгөөг шинэчилж, барилга байгууламжийг өргөжүүлэх
		2.2	Сумын төвийг хатуу хучилттай замтай болгон, орон нутгийн зам харилцааг сайжруулах
		2.3	Орон нутгийн нөөцөд тулгуурлан жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх
		2.4	Мэдээлэл, харилцааны орчин үеийн шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэх /Интернет/
		2.5	Худалдаа үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж эрүүл баталгаатай бүтээгдэхүүнээр хангах

3.	Байгаль экологийн тэнцвэртэй байдлыг хангаж, аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх	3.1	Газар, газрын хэвлийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах, хамгаалах
		3.2	Нөөц боломжид тулгуурлан аялал жуулчлалыг хөгжүүлэх
		3.3	Усны эх үүсвэр, рашаан, бүлгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, нөхөн сэргээж экологийн тэнцвэрт байдлыг хадгалах
		3.4	Сумын нутаг дэвсгэр дэх ашигт малтмалын судалгааг нарийвчилж тогтоох
		3.5	Иргэдэд байгаль экологийн хүмүүжил олгох, уламжлалт зан заншлыг сэргээх /сургалт явуулах/
		3.6	Агаар, газар усны бохирдолт, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох
		3.7	Байгалийн болон түүх дурсгалын үнэт зүйлсийг хашиж хамгаалах
4.	Зөв дадал, зан үйл, эрүүл аж төрөх хэвшилтэй, соёл боловсролтой, амьдрах ухаантай иргэдийг төлөвшүүлэх	4.1	Боловсрол, соёл, эрүүл мэндийн салбарын байгууллагын үйл ажиллагааны чанар, үр дүн, хүртээмжийг дээшлүүлж, орчны стандартыг хангах
		4.2	Банк, санхүү, даатгалын үйлчилгээг иргэдэд ойртуулж, өрсөлдөөн бий болгох, бизнес хөгжих таатай орчин бүрдүүлэх
5.	Үндэсний цөөнхөө дэмжиж ажиллах	5.1	Иргэдийн эрүүл таатай амьдрах орчинг бүрдүүлэх

3.3. Зорилго, зорилтуудын хүрээнд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийн тойм

Зорилго 1

Зорилт 1.1 Цаг уурт тохирсон ашиг шим өндөр хээлтүүлэгч, хээлтэгчийг гаднаас авах, мал сүргийн ашиг шим, таварлаг чанарыг дээшлүүлэн сүргийн бүтцийг сайжруулах		
Хөтөлбөр 1.1.1 Нутгийн шилмэл омгийн мал худалдан авах, цөм сүрэг бүрдүүлэх		
Төсөл	1	Ашиг шим өндөр хээлтүүлэгч, хээлтэгчийг гаднаас худалдаж авах
	2	Цөм сүргийг бүрдүүлж, малын чанарыг сайжруулах
Хөтөлбөр 1.1.2 Мах, сүүний чиглэлийн аж ахуй эрхлэгчдийг дэмжих		
Төсөл	1	Сумын боломжит бүсэд сүүний чиглэлийн үхрийн фермерийн аж ахуйг хөгжүүлэх
	2	Гүүний болон тэмээний сүүний чиглэлийн аж ахуй эрхлэгчдийг дэмжих
	3	Малын нядалгааны цэг барих
Зорилт 1.2 МАА-н материаллаг баазыг бэхжүүлж, байгалийн гамшиг эрсдэлийг давах чадварыг нэмэгдүүлнэ		
Хөтөлбөр 1.2.1 Мал сүргийг эрсдлээс хамгаалах арга хэмжээ		
Төсөл	1	Эрсдлээс хамгаалах тэжээлийн сан байгуулах
	2	Оторын пост барих
	3	Мал дамжин өнгөрөх буудал барих
	4	Бэлчээрийн хортон шавьж, мэрэгчийг устгаж тайлбайг хамгаалах, арга хэмжээ авах
Хөтөлбөр 1.2.2 Мал аж ахуйн материаллаг баазыг бэхжүүлэх		
Төсөл	1	Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах
	2	Хар татар, Жирен, Шар нуур, Могойт, Харгант, Сыргалы орчмын бүсэд усны суваг татаж, талбайг усжуулах
	3	Хуучины хадлангийн талбайг усжуулах, хашаалах
	4	Малын тоог бэлчээрийн даацад тохируулах

	5	Хадлангийн талбайг шинээр бий болгох, хадлангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэдийг дэмжих
Зорилт 1.3 Мал эмнэлэгийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, мал сүргийг эрүүлжүүлэх		
Хөтөлбөр 1.3.1 Мал сүргийг эрүүлжүүлэх		
Төсөл	1	Хувийн хэвшлийн мал эмнэлэгийн үйл ажиллагааг дэмжих
	2	Сумын нэгдсэн малын эмийн сан байгуулах
	3	Малын гоц халдварт өвчин болон бүх төрлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх сан байгуулах
Зорилт 1.4 Газар тариалангийн усалгаатай талбайг нэмэгдүүлж, сумын хүн амыг төмс, хүнсний ногооны хэрэгцээг өөрийн бүтээгдэхүүнээр хангах		
Хөтөлбөр 1.4.1 Газар тариалангийн усалгаатай талбайг нэмэгдүүлэх		
Төсөл	1	Тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийг дэмжих
	2	Нэгдсэн тариалангийн талбайг шинээр бий болгох, иргэдэд эзэмшүүлэх
	3	Хуучин хадлангийн талбайн усжуулалтын сүлжээг шинэчлэх
Хөтөлбөр 1.4.2 Өөрсдийн тариалсан хүнсний бүтээгдэхүүнээр хангах		
Төсөл	1	Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх
	2	Иргэдийг газар тариалангийн ажилд сургах

Зорилго 2

Зорилт 2.1 Сумын төвийн ерөнхий төлөвлөгөөг шинэчилж, барилга байгууламжийг өргөжүүлэх		
Хөтөлбөр 2.1.1 Сумын төвийн ерөнхий төлөвлөгөө гаргах		
Төсөл	1	Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах /2030 он хүртэлх/
Хөтөлбөр 2.1.2 Хот, барилга байгууламжийг өргөжүүлэх		
Төсөл	1	Соёлын төвийн барилга байгууламжийг шинээр барих
	2	Нийтийн халуун ус барих
	3	Хүүхдийн цэцэрлэгийг шинээр барих
	4	Сургуулийн байрыг шинээр барих
	5	Доод гудамжинд бага сургууль барих
	6	Дулааны станцын байгууламж барих
	7	Цэвэр усны байгууламж барих
	8	Цэвэрлэх байгууламж барих
	9	Ногоон байгууламж бүхий цэнгэлдэх хүрээлэн, парк байгуулах
	10	Сургуулийн дотуур байр, гал тогоо барих
	11	Тыва бага сургуулийн байрыг шинээр барих
	12	Эрчим хүчний дэд станцуудыг шинэчлэх, шинээр барих, хүчин чадлыг нэмэгдүүлэх
	13	Орон сууцны хороолол төлөвлөж барих
	14	Худалдааны болон ахуйн үйлчилгээний төв барих
	15	Хүүхдийн парк барих
	16	Онгоцны буудал барих
	17	Төв талбайтай болох
	18	Хөл бөмбөгийн талбай барих
	19	Хүүхдийн хөдөлмөр, амралт зугаалгын газар
	20	Ахмадын ордон барих
	21	Эх хүүхдийн сувилахуйн байр
Зорилт 2.2 Сумын төвийг хатуу хучилттай замтай болгон, орон нутгийн зам харилцааг сайжруулах		
Хөтөлбөр 2.2.1 Зам харилцаа, гудамжийн зохион байгуулалтыг сайжруулах		
	1	Улаанхус, Цэнгэл сумын чиглэлийн замыг засах

Төсөл	2	Сумын төвийг хамарсан хатуу хучилттай замтай болгох
	3	Зам дагасан гэрэлтүүлэг тавих, ногоон байгууламжтай болгох
	4	Хогийн сав тавих
	5	Бүх айл өрхүүдийг хаягжуулах, дугаартай болгох
Зорилт 2.3. Орон нутгийн нөөцөд тулгуурлан жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх		
Хөтөлбөр 2.3.1 Мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих		
Төсөл	1	Сүү, махны чиглэлийн фермерийн аж ахуйг хөгжүүлэх
	2	Ноос, ноосон бүтээгдэхүүнийг боловсруулах анхан шатны үйлдвэр барих
	3	Арьс шир, ноолуур боловсруулах цех байгуулах
Хөтөлбөр 2.3.2 Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих		
Төсөл	1	Талх нарийн боовны цех байгуулах
	2	Цагаан идээ боловсруулах цех байгуулах
Хөтөлбөр 2.3.3 Аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх		
Төсөл	1	Мод, модон үйлдвэрлэлийг хөгжүүлэх
	2	Орон нутгийн урчуудын гутлын үйлдвэр барих
	3	Барилгын бараа материал үйлдвэрлэлийг хөгжүүлэх
	4	Гар урлалыг хөгжүүлэх
	5	Машин техникийн засварын цех байгуулах
Зорилт 2.4 Мэдээлэл, харилцааны орчин үеийн шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэх		
Хөтөлбөр 2.4.1 Орчин үеийн дэвшилтэд технологийг нэвтрүүлэх		
Төсөл	1	Интернетэд холбох
	2	Байгууллагуудыг дотоод сүлжээнд холбох
	3	Интернет кафе бий болгох
	4	Ард иргэдийг харилцаа холбооны операторуудын үйлчилгээгээр бүрэн хангах
Зорилт 2.5 Худалдаа үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, эрүүл баталгаатай бүтээгдэхүүнээр хангах		
Хөтөлбөр 2.5.1 Худалдаа үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж		
Төсөл	1	Хүнсний эрүүл ахуйн менежментийг боловсруулан хэрэгжүүлэх

Зорилго 3

Зорилт 3.1 Газар, газрын хэвлийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах, хамгаалах		
Хөтөлбөр 3.1.1 Ашигт малтмалын нөхөн сэргээлтийг сайжруулах		
Төсөл	1	Гянт болдын уурхайд ногоон байгууламж байгуулах, хиймэл нуур барих, Ховдын хавцлын замыг засах
	2	Улаан тоосгоны үйлдвэр Цагаанголын шаврын карьерд нөхөн сэргээлт хийх, Ховд голын модон гүүрийг засах, хогийн менежментийг сайжруулах
Зорилт 3.2 Нөөц боломжид тулгуурлан аялал жуулчлалыг хөгжүүлэх		
Хөтөлбөр 3.2.1 Аялал жуулчлалыг хөгжүүлэх		
Төсөл	1	Амралт зугаалгын газар байгуулах
	2	Аялал жуулчлалын бааз байгуулах
	3	Цагаан голын гарамд гүүр барих
	4	Алтай Таван богд, Сыргалы, Цагаан усыг түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлэх
	5	Тусгай хамгаалалтын бүсэд аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа эрхлэх боломжийг бүрдүүлэх
Зорилт 3.3 Усны эх үүсвэр, рашаан, булгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, нөхөн сэргээж экологийн тэнцвэрт байдлыг хадгалах		
Хөтөлбөр 3.3.1 Усны эх үүсвэр, рашаан, булгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, нөхөн сэргээж экологийн тэнцвэрт байдлыг хадгалах		
	1	Рашаан, булгийн эхийг хашиж хамгаалах, ойжуулах
	2	Ховд голын ашиглалт, хамгаалалтыг сайжруулах

Төсөл	3	Гол горхи хамгаалах сан байгуулах
	4	Ховд голын эрэгт ногоон байгууламж барих, ойжуулалт хийх
Зорилт 3.4 Сумын нутаг дэвсгэрт дэх ашигт малтмалын судалгааг нарийвчилж тогтоох		
Хөтөлбөр 3.4.1 Ашигт малтмалын судалгааг нарийвчилж тогтоох		
Төсөл	1	Хайгуулийн судалгаа хийх
	2	Газрын нэгдмэл сангийн ангиллын тоо бүртгэлийг сайжруулах
Зорилт 3.5 Иргэдэд байгаль экологийн хүмүүжил олгох, уламжлалт зан заншлыг сэргээх		
Хөтөлбөр 3.5.1 Байгаль орчныг хамгаалахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх		
Төсөл	1	Байгаль экологийн кабинет байгуулах
	2	Байгаль орчны талаар сургалт зохион байгуулах
	3	Орон нутаг судлалын танхимыг шинээр нээж, үйл ажиллагааг эрчимжүүлэх
Зорилт 3.6 Агаар, хөрс, усны бохирдолт, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох		
Хөтөлбөр 3.6.1 Хог хаягдлын менежментийг сайжруулах		
Төсөл	1	Хог хаягдлыг цэвэршүүлэхэд шинэ технологи нэвтрүүлэх
	2	Хог боловсруулах цэг байгуулах
	3	Хогийн менежмент боловсруулах
Хөтөлбөр 3.6.2 Ус, агаарын бохирдолтой тэмцэх		
	1	Айл өрхүүдийг эко бие засах газартай болгох
	2	Дээд, доод гудамжийн айл өрхүүдэд ундны усны гүний худаг гаргах
Зорилт 3.7 Байгалийн болон түүх дурсгалын үнэт зүйлсийг хашиж хамгаалах		
Хөтөлбөр 3.7.1 Байгалийн болон түүх дурсгалын үнэт зүйлсийг хамгаалах		
Төсөл	1	Байгалийн болон түүх дурсгалын музей барих
	2	Байгалийн болон түүх дурсгалын үнэт зүйлсийг хаших /Хүн чулуу, эртний түүхт булш/

Зорилго 4

Зорилт 4.1 Боловсролын салбарын байгууллагын үйл ажиллагааны чанар, үр дүн, хүртээмжийг дээшлүүлж, орчны стандартыг хангах		
Хөтөлбөр 4.1.1 Боловсрол, соёл, эрүүл мэндийн салбарын орчин нөхцөлийг сайжруулах		
Төсөл	1	Байгууллагуудын ногоон байгууламжийг өргөтгөх
	2	Номын сан байгуулах, номын фондыг шинэчлэх
	3	Дотуур байр, хүн эмнэлэгийн хатуу, зөөлөн эдлэлийг шинэчлэх
	4	Бүх сургуульд багшийн хөгжлийн танхим байгуулах
	5	Хүүхдийн номын сан, тоглоомын талбай барих
	6	Цэцэрлэгийн гал тогооны байрыг тусгаарлах
Хөтөлбөр 4.1.2 Боловсролын салбарын байгууллагын үйл ажиллагааны чанар, үр дүн, хүртээмжийг дээшлүүлэх		
Төсөл	1	Монгол хэлний мэдлэгийг дээшлүүлэх сургалт зохион байгуулах
	2	Монгол, казах хэлний сурах бичгийн тоог олшруулах
	3	Зарим хичээлүүдийн /хими, биологи, физик, дуу хөгжим/танхимын тоноглолыг шинэчлэх, шинээр худалдаж авах
	4	Хувийн хэвшлийн сургууль, цэцэрлэг, эмнэлэгийг дэмжиж ажиллах
	5	“Дотуур байрны хүүхдийн хөгжил” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх
	6	Багш нарын мэргэжил, үр чадварыг дээшлүүлэх
Хөтөлбөр 4.1.3 Эрүүл мэндийн салбарын үйлчилгээг сайжруулах		
Төсөл	1	Биохимийн аппаратыг нийлүүлэх
	2	Шүдний тоног төхөөрөмж нийлүүлэх
	3	Мэс заслын тоног төхөөрөмжийг нийлүүлж, кабинет байгуулах

	4	Хувийн хэвшлийн эмийн санг дэмжих
	5	Хуучин эмлэлгийг сэргээн засварлах
	6	Яаралтай тусламжийн шүүгээ, автоклав, кварц гэрэл нийлүүлэх
	7	Мэдээгүйжүүлэлтийн эмчийг суралцуулах
	8	ХБИ, хүүхдүүдтэй ажиллах байр бий болгох
Зорилт 4.2 Банк, санхүү, даатгалын үйлчилгээг иргэдэд ойртуулж, өрсөлдөөн бий болгох, бизнес хөгжих таатай орчин бүрдүүлэх		
Хөтөлбөр 4.2.1 Бизнес хөгжих таатай орчин бүрдүүлэх		
Төсөл	1	Бүх арилжааны банкуудын салбарыг байгуулах
	2	Арилжааны даатгалын компаниудын үйл ажиллагааг нэвтрүүлэх
	3	АТМ тавих
	4	Сумын засаг захиргаа, бизнес эрхлэгчид, санхүүгийн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөтгөх

Зорилго 5

Зорилт 5.1 Тыва иргэдийн эрүүл таатай амьдрах орчинг бүрдүүлэх		
Хөтөлбөр 5.1.1 Тыва иргэдийн ажиллаж, амьдрах, сурч боловсрох таатай орчныг бүрдүүлэх		
Төсөл	1	Тыва бага сургуулийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх
	2	Тыва хүүхдүүдийг СӨБ-д бүрэн хамруулах, цэцэрлэг барих
	3	Сурах бичгийг Тыва хэлэнд хөрвүүлэх багийг дэмжих
	4	Тыва хэлний сурах бичгийг хэвлэх ажиллагааг дэмжих

3.4. Төлөвлөгөөг хэрэгжүүлэгч талууд, тэдний оролцоо, хүлээх үүрэг

№	Оролцогч талууд	Оролцох үндэслэл	Ашиг сонирхол	Нөлөөлөх түвшин
1	Иргэд	Тэд санаа гаргаж, төлөвлөж, хэрэгжүүлэхэд оролцож, үр дүнг хянаж байх	Төлөвлөгөөг иж бүрэн хэрэгжүүлж үр ашгийг хүртэх	Өндөр
2	Бизнес, аж ахуйн нэгж	Бизнес, аж ахуйн нэгжүүд нь байгууллагын хувьд төлөвлөлтөнд өөрсдийн хөгжлийн чиг хандлагыг тусгах, хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулах	Сумын төлөвлөгөөний хэрэгжилтийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, орон утгийн нөөцөд тулгуурлан өөрсдийн бизнесийг өргөтгөх	Өндөр
3	Иргэний нийгэм, ТББ	Олон нийт, гишүүдийн санааг илэрхийлэх, төлөвлөгөөний хүрээний арга хэмжээнүүдийн хэрэгжилтэнд хяналт тавих, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, шударга байхад чиглэсэн дуу хоолой гаргаж байх	Төлөвлөгөөний биелэлтийг хангахад өргөн оролцоог хангах, нийтлэг эрх ашгийг хамгаалж, дуу хоолой илэрхийлэх	Өндөр
4	Сумын төрийн байгууллага	Төлөвлөгөөг эцэслэн батлах, хэрэгжилтийг зохион	Төлөвлөгөөг зохиох, хэрэгжүүлэх үйл ажиллагааг	Өндөр

		байгуулах гол үүрэг, хариуцлагыг хүлээх, биелэлтийг хянах	удирдан зохицуулах, сумын хөгжлийг хангах, нэр хүндтэй болох	
5	Олон улсын байгууллага төсөл, хөтөлбөр, хандивлагч, хөрөнгө оруулагч	Хөгжилд дэмжлэг үзүүлэн, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	Дэмжлэг, хөрөнгө оруулалтын ашиг үр дүн	Өндөр
6	Сумын төлөвлөлт, хяналтын хороо	Төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцох үүрэгтэй	Төлөвлөгөөний бодит байдлыг хангах, хянах, зохицуулалт хийх асуудлыг шуурхай зохион байгуулах, олон нийтийн төлөөллийн оролцоог хангах	Дунд
7	Нутгийн зөвлөл	Хөгжилд дэмжлэг үзүүлэх, сурталчлахад оролцох	Арга зүй, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх	Дунд

3.5. Хөрш зэргэлдээ сумдтай хамтран ажиллах

Сумын нэр	Хамтран ажиллах чиглэл	Хөрш суманд санал болгох бүтээгдэхүүн	Хөрш сумаас авах бүтээгдэхүүн
Улаанхус сум	Алтай Таван богд чиглэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, Ховор ан амьтан хамгаалах, Малын хулгайтай тэмцэх	Иргэдийг рашаан сувилалд амруулах, малын гаралтай бүтээгдэхүүн, Түлшний болон ахуйн хэрэглээний мод, модон эдлэл, малын бэлчээр, улаан тоосго	Малын бэлчээр, шохой, хужир, шүү, зосон будаг
Сагсай сум	Малын хулгайтай тэмцэх, зосон будаг нийлүүлэх	Иргэдийг рашаан сувилалд амруулах, малын гаралтай бүтээгдэхүүн, Түлшний болон ахуйн хэрэглээний мод, модон эдлэл, малын бэлчээр, улаан тоосго	Малын бэлчээр, зосон будаг, өнгөт тоосго, хүнсний ногоо

Дөрөвдүгээр бүлэг. ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭРЭГСЭЛ

4.1.Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын удирдлага, зохион байгуулалт

Хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь Монгол улсын хуулийн хүрээнд хөгжлийн тухай баримт бичиг, нийгэм эдийн засгийн хөгжлийн чиглэл, төсвийн талаарх эрх зүйн акт, бусад хууль тогтоомж, хамтран ажиллагсадтай байгуулсан гэрээ хэлцэлийн дагуу зохион байгуулагдана.

Уялдуулан зохицуулах тогтолцоо

Баян-Өлгий аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга

